



**ТОГВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ
ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН
САНААЧЛАГА ТББ**



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 2010.01.01-2010.12.24

Боловсруулсан: Ч. Ундрам
Огноо: 2010.12.24



**ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ
ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН
САНААЧЛАГА ТББ**



ГАРЧИГ

1.	ХУРААНГУЙ	3
2.	ҮЙЛ АЖИЛЛАГАА	5
2.1	<i>Зорилго I. Үнэлгээ, мониторинг, судалгаа хийх</i>	6
2.2	<i>Зорилго II. Мэдээлэл сурталчилгаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх</i>	7
2.3	<i>Зорилго III. Хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгоход нөлөөлөх</i>	9
2.4	<i>Зорилго IV. Байгууллагын зохион байгуулалт, санхүүжилтийг бэхжүүлэх</i>	10
3.	ДҮГНЭЛТ	11
3.1	Үр дүн	12
3.2	Цаашид анхаарах зүйл	13



**ТОГВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ
ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН
САНААЧЛАГА ТББ**



ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

1.	<i>Хавсралт-1</i> Санаачлагын санхүүжилтийн журам	14
2.	<i>Хавсралт-2</i> Хяналтын зөвлөлийг сонгох журам	17
3.	<i>Хавсралт-3</i> Удирдах зөвлөлд иргэний нийгэм болон үйлдвэрлэгчдийн төлөөлөл сонгох журам	21
4.	<i>Хавсралт-4</i> Санаачлагын АНУ-ын Азийн сантай 2010-2013 онд хамтран ажиллах стратеги төлөвлөгөө	27
5.	<i>Хавсралт-5</i> Хамтын ажиллагаа, түншлэлийн хүрээнд хийсэн уулзалт, хурлууд	35
6.	<i>Хавсралт-6</i> Хэвлэл, нийтлэл, ярилцлагууд	45

1. ХУРААНГҮЙ



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН САНААЧЛАГА ТББ



Үйл ажиллагаа:

Ажлын алба Удирдах зөвлөлөөс баталсан Санаачлагын 2009-2020 хүртэл баримтлан ажиллах стратеги төлөвлөгөөний үндсэн 4 зорилгын хүрээнд “Үнэлгээ мониторинг судалгаа хийх”, “Мэдээлэл сурталчилгаа хамтын ажиллагааг хөгжүүлэх”, “Хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгоход нөлөөлөх”, “Байгууллагын зохион байгуулалт санхүүжилтийг бэхжүүлэх” болон Удирдах зөвлөлийн 12-р хурлаас баталсан Санаачлагын 2010 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу тодорхой үйл ажиллагаануудыг хийж гүйцэтгэсэн ба эдгээрээс томоохон үйл ажиллагаанууд нь “MINE IT” мэдээлэл технологийн үзэсгэлэн, уул уурхайн компаниудад зориулсан сургалтууд, болон уул уурхайн компаниудын дунд мэдлэг мэдээлэл солилцох “сүлжээ” үүсгэх юм.

Гадаад харилцаа:

Энэ онд ажлын албанаас Санаачлагын стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд санхүүжилтийг нэг байгууллагаас хараат бус болгох, санхүүжилтийн эх үүсвэрийг оролцогч талуудаас бүрдүүлэх механизмыг бэхжүүлэх, гадаад харилцааг өргөжүүлэн тэлэх чиглэлээр анхааран ажилласан бөгөөд үүний үр дүнд:

- АНУ-ын хөгжлийн хөтөлбөрийн “Эдийн засгийн бодлогын өрсөлдөх чадвар төсөл” болон “Монголын програм хангамжын холбоо”-той хамтран “MINE IT 2010” мэдээллийн технологийн үзэсгэлэнг Хаан палас зочид буудалд зохион байгуулсан.
- АНУ-ын Азийн сангийн Байгаль орчны хөтөлбөрийн хүрээнд 2010 оны 4-р улирлаас хөтөлбөрийг дуусах хүртэл хамтран ажиллах стратегийг Удирдах зөвлөлөөс томилогдсон ажлын хэсгийн хамтаар боловсруулан хүргүүлсэн.
- Дэлхийн Банктай урьдын тогтоосон харилцаагаа бататгасан. (Дэлхийн Банк энэ онд Квийнсландын их сургуулийн уул уурхай, нийгмийн хариуцлагын төвөөс Санаачлагад хийсэн судалгаа, Уул уурхай ба орон нутаг, нутгийн иргэдтэй харилцах нь сэдэвт чуулга уулзалтыг санхүүжүүлэн ажилласан)
- Германы техник хамтын ажиллагааны нийгэмлэгтэй 2011 онд стратегийн түншлэлийг бий болгон Санаачлагын харьяа “ХУУ-н мэдээллийн төв” байгууллан ажиллах анхны алхамуудыг гүйцэтгэсэн.
- Зүүн ази номхон далайн бүсийн орнуудын нийгмийн хариуцлагын төлөөх сүлжээний (ANSA EAP) “Revenue Watch Institute” -ийн тусламжаар хэрэгжүүлэх олборлох салбарын иргэний нийгмийн байгууллагуудын нийгмийн хариуцлагыг бэхжүүлэх 2 жилийн хөтөлбөрт оролцохоор саналаа илгээсэн. Одоогын байдлаар энэхүү хөтөлбөрт Зүүн өмнөд азийн 4 орон хамрагдаж байсан бөгөөд Монгол улс буюу Санаачлага 5 дахь орон болон орж байгаа болно.
- Хэвлэлийн хүрээлэнгийн эдийн засаг, уул уурхайн чиглэлээр бичдэг сэтгүүлчдэд зориулсан сургалтыг АНУ-ын хөгжлийн хөтөлбөрийн “Эдийн засгийн бодлогын өрсөлдөх чадвар төсөл” хамтран хийхээр төлөвлөж байна.

Удирдах зөвлөл:



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН САНААЧЛАГА ТББ



2010 онд удирдах зөвлөл нийт 6 удаа хуралдаж, Удирдах зөвлөл болон удирдах зөвлөлөөс томилогдсон ажлын хэсгүүд Санаачлагын цаашдын үйл ажиллагааг тогтворжуулахад нэн шаардлагатай баримт бичгүүдийг боловсруулан гаргасан. Үүнд: Санаачлагын санхүүжилтийн журам /Хавсралт.1/, Хяналтын зөвлөлийг сонгох журам /Хавсралт.2/, Удирдах зөвлөлд иргэний нийгэм болон үйлдвэрлэгчдийн төлөөлөл сонгох журам /Хавсралт.3/, ХУУ-н шалгуур үзүүлэлтийн анхны төсөл гэх мэт.

Санхүү:

Ажлын алба 2010 оны 1 сараас 8 сар хүртлэх захиргааны зардлыг 2009 оноос үлдсэн үйл ажиллагааны орлого болон Уул уурхай мэдээллийн технологи экспо зохион байгуулсаны төлбөр, Уул уурхайн компанийн орон нутаг, нутгийн иргэд хариуцсан ажилтнуудад зориулсан сургалт зохион байгуулсан төлбөр, Квийнсландын их сургуулиас Санаачлагад хийсэн судалгааны санхүүжилтийн төлбөрөөс үлдсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлж, 9-12 сарын захиргааны зардлыг АНУ-ын Азийн сантай хамтран хэрэгжүүлэх Монгол улсад хариуцлагатай уул уурхайг төлөвшүүлэх төслийн дагуух санхүүжилт болон Уул уурхай ба орон нутаг, нутгийн иргэдтэй харилцах нь анхдугаар форум зохион байгуулах санхүүжилтээр ажилласан. 2010 онд Санаачлагаас зохион байгуулсан үйл ажиллагааны орлого болон АНУ-н Азийн сангаас нийт 154,463,898.55 төгрөгийн санхүүжилт хийгдсэн бөгөөд энэхүү санхүүжилтийн дэлгэрэнгүй тайлантай 2010 оны санхүүгийн тайлан эцэслэгдэн гарахаар танилцана уу. Санаачлагын санхүүжилтийн ил тод байдлыг хангах зорилгоор Удирдах зөвлөлийн даргын санаачлагаар 2010 оны 12 сард Аудит орж байгаа бөгөөд энэхүү аудит нь 2008 оноос одоог хүртэл хийгдсэн санхүүгийн үйл ажиллагааг шалган дүгнэлт гаргах юм. Аудитийн үр дүнг гармагц удирдах зөвлөлийн гишүүдэд мэдээллэх болно.

Үр дүн:

Дээрх үйл ажиллагааг хийж гүйцэтгэснээр Санаачлагыг байгууллагын хувьд өөрийн оролцогч талуудын төлөөлөл болох олон улсын байгууллагууд, үйлдвэрлэгчдэд Санаачлагын үйл ажиллагаа, чадавхийг олон нийт, оролцогч талууд, олон улсын байгууллагуудад таниулан, цаашид урт хугацаанд үргэлжлэхүйц томоохон ажлуудын эхлэл суурийг тавьж байгууллагын хамтын ажиллагаанд тодорхой ахиц гаргасан. Хамгийн гол нь Санаачлагын санхүүжилтийг тодорхой нэг донор байгууллагаас хараат бус байлгах үйл ажиллагааны эхлэл амжилттай тавигдсан.

Цаашид анхаарах зүйл:

Санаачлага 2011 онд иргэний нийгмийн төлөөлөлд чиглэсэн үйл ажиллагаа тэр дундаа орон нутагт байгаль орчин хамгаалах чиглэлээр байгуулагдсан санаачлага, иргэдийн бүлэг, төрийн бус байгууллагуудад тэдний ХУУ-н чиглэлээрх мэдлэг, мэдээллийг сайжруулах үйл ажиллагаа зохион байгуулах, оролцогч талуудын хурлыг хот болон орон нутгийн түвшинд зохион байгуулах шаардлагатай байна. Мөн Удирдах зөвлөлийн гишүүд өөрсдийн төлөөлсөн оролцогч талаас сан бүрдүүлэх үйл ажиллагаанд идэвхитэй оролцох шаардлагатай байна.

2. ҮЙЛ АЖИЛЛАГАА



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН САНААЧЛАГА ТББ



Ажлын алба:

Ажлын алба дараах бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа эрхлэн гүйцэтгэлээ: 2010 оны 2 дугаар сарын 04-нд Удирдах зөвлөлийн дарга А. Бакей үүрэгт ажлаа хүлээлгэн өгсөнөөр дараагийн Удирдах зөвлөлийн даргаар Д. Хэрлэн 2010 оны 2 дугаар сарын 08-ны өдрөөс Удирдах зөвлөлөөс томилогдон ажиллаж байна. Мөн Ажлын алба шинээр 4 ажилтантай болсон.

Ажлын албаны бүтэц 2010 онд:

1. 2010 оны 01 дүгээр сараас 02 дугаар сарын 04 хүртэл:
 - Удирдах зөвлөлийн дарга А. Бакей
 - Гүйцэтгэх захирал – Ч. Ундрэм
 - Оффис менежер – М. Ганчимэг
2. 2010 оны 02 дугаар сарын 08 наас 2010 оны 8 дугаар сарын 01 хүртэл:
 - Удирдах зөвлөлийн дарга Д. Хэрлэн
 - Гүйцэтгэх захирал – Ч. Ундрэм
 - Оффис менежер – М. Ганчимэг
3. 2010 оны 8 дугаар сараас 11 дүгээр сар хүртэл:
 - Удирдах зөвлөлийн дарга Д. Хэрлэн
 - Гүйцэтгэх захирал – Ч. Ундрэм
 - Германы техник хамтын ажиллагааны нийгэмлэгийн СИМ хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр Байгууллагын хөгжил, харилцаа хариуцсан эксперт О. Батболдыг 2010 оны 8 сард, ажиллах хугацаа 2 жилээр
 - Оффис менежер – М. Ганчимэг
4. 2010 оны 11 сараас хойш:
 - Удирдах зөвлөлийн дарга Д. Хэрлэн
 - Гүйцэтгэх захирал – Ч. Ундрэм
 - Байгууллагын хөгжил, харилцаа хариуцсан эксперт О. Батболд
 - Оффис менежер – М. Ганчимэг
 - Дэлхийн Банкнаас уул уурхайн компаниудын дунд компаний нийгмийн хариуцлага, орон нутаг, нутгийн иргэдтэй харилцах чиглэлээр мэдлэг мэдээлэл солилцох сүлжээ үүсгэхийг дэмжсэний дагуу Байгууллагын арга хэмжээ зохион байгуулагч П. Соёлмааг 2010 оны 11 сард, ажиллах хугацаа 4 сар
 - Азийн сангийн байгаль орчны хөтөлбөрийн хүрээнд хариуцлагатай уул уурхайн шалгуур үзүүлэлтийг турших төслийг эхлүүлсэнтэй холбоотойгоор төслийн менежер Ч. Батчимэг, Төслийн туслах ажилтан Э. Өнөболд нарыг 2010 оны 11 сард, туршилтын хугацаа 3 сар, тус тус ажиллуулж эхлээд байна.

2010 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН 4 ЗОРИЛГО:



ТОГВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН САНААЧЛАГА ТББ



2.1 Зорилго I. Үнэлгээ, мониторинг, судалгаа хийх

Хариуцлагатай уул уурхайн 8 зарчмыг хэрэгжүүлэх суурийг тавих үйл ажиллагааны хүрээнд:

Боловсруулалт:

Хариуцлагатай уул уурхайн шалгуур үзүүлэлт боловсруулах ажлын хэсэг баталсан шалгуур үзүүлэлтүүдэд үндэслэн түүнийг үнэлэх аргачлалыг боловсруулж дуусгасан. Энэ ажлын хүрээнд ажлын хэсгийн гишүүд (Б. Арвинбаяр, Г. Батсайхан, Л. Долгормаа, Б.Баярмаа, А. Бакей, Л. Батнасан) нийт 7 удаа хуралдсан бөгөөд Удирдах зөвлөлийн гишүүд нэг удаагийн уулзалтын урамшуулалд 30,000 төгрөг авсан. Энэхүү зардлыг Азийн сангийн санхүүжилтээс гаргасан.

Санхүүжилт болон хэрэгжүүлэлт:

Хариуцлагатай уул уурхайн шалгуур үзүүлэлтийг турших төслийг хэрэгжүүлэх үүднээс төслийг боловсруулан Азийн санд илгээж Санаачлага болон Азийн сангийн 2010-2013 онд хамтран ажиллах стратеги төлөвлөгөөнд /Хавсралт.4/ тусган санхүүжилтээ авч эхэлсэн. Энэ ажлын дагуу Ажлын алба төслийн менежер болон төслийн туслах ажилтныг сонгон шалгаруулж авсан бөгөөд эхний туршилтыг Оюу Толгой ХХК дээр 2011 оны 01-р сараас 02-р сарын 25 хооронд хэрэгжүүлэхээр төслийн баг судалгааны бэлтгэл ажлуудыг эхлүүлээд байна.

2010 оны 9 сарын 22-ны өдөр дээрх ажлын хэсэг нь Азийн сангийн Байгаль орчны хөтөлбөрийн дарга Энжи Вү болон Азийн сангийн хөтөлбөрийн ажилтануудтай уулзан өнгөрсөн хугацаанд Санаачлагаас хэрэгжүүлсэн үйл ажиллагаа болон цаашдын хамтын ажиллагааны талаар ярилцаж, өөрсдийн боловсруулсан стратеги төлөвлөгөөгөө танилцуулсан. Уулзалтын дүнд Азийн сан ирэх 3 жилд Санаачлагатай хамтран ажиллах төлөвлөгөөтэй танилцан өөрсдийнхөө төлөвлөгөөнд оруулах болно, мөн энэхүү стратеги төлөвлөгөөнд орсон үйл ажиллагаануудаас нэн тэргүүний хэрэгжүүлэх үйл ажиллагаануудын жагсаалт, төслийг /2010 он дуустлах үйл ажиллагааны болон захиргааны зардлыг багтаасан/ 2010 оны 9 сарын 28-ны дотор боловсруулж ирүүлнэ үү гэсэн хүсэлт тавьсан болно. Энэ дагуу дээрх ажлын хэсэг болон ажлын алба стратеги төлөвлөгөөний нэн тэргүүнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төслийг боловсруулан Азийн санд хүргүүлсэн. (Ажлын албаны мэдээ 2010 оны 10-р сарын 1)

Хамтын ажиллагаа:

1. Байгаль орчин аялал жуулчлалын яаманд Санаачлага ХУУ-н шалгуур үзүүлэлтийн хүрээнд урт хугацаанд хамтран ажиллах саналыг тавьж, хамтын ажиллагааны гэрээ, санамж бичиг байгуулах тухай эхний уулзалтуудыг удирдах зөвлөлийн дарга Д.Хэрлэн болон ХУУн шалгуур үзүүлэлт боловсруулах ажлын



ТОГВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН САНААЧЛАГА ТББ



- хэсгийн дарга Л.Долгормаа, гишүүн Г.Батсайхан ажлын алба гэсэн бүрэлдэхүүнтэйгээр 2 удаа амжилттай зохион байгуусан.
- ХУУ-н шалгуур үзүүлэлтийг банкны салбарт уул уурхайн компаниудад зээл олгохдоо хэвшүүлэн ашиглах талаар саналыг Хас Банкнаас Санаачлагад тавьсан бөгөөд энэхүү саналыг ХУУ-н шалгуур үзүүлэлтийн туршилтын төслийн дараагаар нарийвчлан хэлэлцэхээр болсон.
 - Мобиком корпораци төрийн яамд, агентлагуудын тайлан авдаг механизмыг электрон хэлбэрт шилжүүлэх талаар хэлэлцэж байгаа бөгөөд үүнтэй холбоотойгоор ХУУ-н шалгуур үзүүлэлтийн үнэлгээг хийхэд шаардлагатай мэдээллийг электрон хэлбэрт оруулан хамтран ажиллах боломжийн талаар Санаачлагад саналаа тавьсан бөгөөд энэхүү ажлыг мөн шалгуур үзүүлэлтийн туршилтын төслийн дараагаар нягтлан хэлэлцэх боломжтой.

Бусад:

Удирдах зөвлөлийн даргын шийдвэрээр Хариуцлагатай уул уурхайн шалгуур үзүүлэлтэд Санаачлагын үүсгэн байгуулагч Удирдах Зөвлөлийн гишүүдийн нэр дээр 2010 оны 5 сарын 20-ны өдөр Монгол улсын тэргүүн шадар сайдын 44 тоот тушаалаар Зохиогчийн эрхийн гэрчилгээ авсан.

2.2 Зорилго II. Мэдээлэл сурталчилгаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх

Хариуцлагатай уул уурхайн тухай ойлголтыг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх

Боловсруулагдсан баримт бичиг:

- Санаачлагын харилцааны стратегийг сайжруулан боловсруулах, 2010 онд хийх ажлуудтай уялдсан олон нийттэй харилцах талаар нарийвчилсан төлөвлөгөө боловсруулах ажлыг харилцааны мэргэжилтэн, гэрээт ажилтан А. Алтангэрэл 2010.01 сараас 2010.05 саруудад 4 сарын хугацаатайгаар ажиллан боловсруулан гаргасан. Энэ ажлын үр дүнд Санаачлагын оролцогч талуудад тохирсон мессеж бэлтгэгдэн, хэвлэлийн бага хуралд хэрэглэх ерөнхий удирдамж гарч мэдээний загвар, танилцуулга, илтгэлүүд сайжруулагдан боловсруулагдсан.

Оролцсон дотоодын болон олон улсын хурал чуулган:

- Камбож улсад энэ оны 5 дугаар сарын 26-28-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Олон улсын уул уурхайн чуулган”-д Санаачлагад ирсэн урилгын дагуу Удирдах зөвлөлийн гишүүн З. Батбаяр оролцоод ирсэн.
- 2010 оны 9 сарын 8-9-ний өдрүүдэд зохион байгуулагдсан Уул уурхайн олон улсын хөрөнгө оруулагчдын чуулга уулзалтад Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн дэмжлэгтэйгээр УЗ-ийн гишүүн Л. Долгормаа “Монгол улсад хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх нь” сэдвээр илтгэл тавьж оролцсон. Мөн Санаачлага уг чуулга уулзалтын үзэсгэлэнгийн талбайд Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагатай хамтран байрлаж, байгуулагаа танилцуулсан.
- 2010 оны 10 сарын 13-ны өдөр Дэлхийн банкнаас 10 сарын 16-27-ны өдрүүдэд Пилиффин улсын Манила хотод зохион байгуулагдсан Нийгмийн хариуцлагын төлөөх сүлжээний уулзалтын талаарх хуралд Гүйцэтгэх захирал Ч. Ундрам оролцсон.



ТОГВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН САНААЧЛАГА ТББ



4. 2010 оны 10 сарын 21-11 сарын 7-ний өдрүүдэд Байгууллагын хөгжил, харилцаа хариуцсан мэргэжилтэн О. Батболд Германы Берлин, Бонн-д FES, CIM-ийн шугамаар зохион байгуулагдах Эх орондоо эргэн ирэх сургалтад зохион байгуулагчаар, ГТХАН-ийн Фабиантай Санаачлагад ирэх оны эхээр ирэх Герман мэргэжилтнийг хурдан ирүүлэх талаар уулзан, албан бичиг хүргэсэн. Мөн 2010 оны 10 сарын 29-өөс 31-ны хооронд Штуттгарт хотноо зохион байгуулагдсан Хамтдаа хүчтэй сэдэвт Германд төгссөн болон одоо сурч буй монголчуудын эрдэм шинжилгээний хуралд “ХУУ Монголд” сэдэвээр илтгэл тавин оролцсон.
5. Ажлын албанаас Санаачлагыг оролцогч талуудад таниулах, хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор 2010 онд нийт 84 удаагийн уулзалт, семинарт оролцон Санаачлагаас хийж гүйцэтгэсэн болон хийхээр төвлөж буй үйл ажиллагаанууд мөн хамтын ажиллагааны шинэ боломжуудын талаар мэдээлэл өгч санал солилцож байсан ба хамгийн чухал баримтлаж байсан бодлого бол ХУУн 8 зарчимаа сурталчилан таниулах байлаа. Эдгээрийн жагсаалтыг /Хавсралт.5/-аас харна уу.

Хамтран ажилласан хэвлэл мэдээллийн хэрэгсэл:

1. ХУУ-н 8 зарчмаар цуврал нэвтрүүлэг хийж, телевизээр явуулахад шаардлагатай уулзалтуудыг хийж, Хариуцлагатай уул уурхайн шалгуур үзүүлэлтийн үйл ажиллагаа, явцыг олон нийтэд танилцуулах зорилгоор Танин мэдэхүйн телевизийн “Хариуцлагатай уул уурхай” 30 минутын нэвтрүүлэгт 2 удаа оролцох эрх өгсний дагуу эхний нэвтрүүлгээр нь /2010-06-20-нд/ Хариуцлагатай уул уурхайн шалгуур үзүүлэлт боловсруулах ажлын хэсгийн гишүүд А. Бакей, Л. Долгормаа, Г. Батсайхан нар ярилцлага өгсөн. Хоёрдахь нэвтрүүлгийн цагт /2010-06-27-нд/ Санаачлагын Удирдах зөвлөлийн гишүүн З. Батбаяр оролцож Камбожи улсад болсон “Олон улсын уул уурхайн чуулганы ” талаархи мэдээллийг хүргэсэн. /Ярилцлагыг ажлын албан дээрээс авч болно./
2. Санаачлага 2010 онд нийт 15 удаагийн ярилцлагыг Геологи уул уурхайн сонин, Өглөөний мэдээ сонин, Улаанбаатар таймс, Монголика сэтгүүл, өдрийн сонин, үндэсний шуудан, Монголын радио зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслээр гаргасан. Ярилцлага болон ярилцлагын жагсаалттай /Хавсралт.6/-аас танилцана уу.
3. 2010 оны эцсээр Санаачлагатай 2011 оны туршид хамтран ажиллахаар болсон хэвлэл мэдээллийн хэрэгслүүд:
 - Геологи уул уурхайн мэдээ сонин
 - Mining Journal
 - Боловсрол телевиз

Гурван талын хамтын ажиллагааг бэхжүүлэх, өрнүүлэх

2010 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний Уул уурхайн компаниудын дунд форум, семинар, чуулга уулзалт зохион байгуулж туршлага солилцуулах, үүнд ТББ, төрийн байгууллагуудын төлөөллийг оролцуулах гэсэн зорилтын дагуу

1. Квийнсландын их сургуулийн уул уурхай нийгмийн хариуцлагын төвтэй хамтын ажиллагааны санамж бичигт 2010 тавдугаар сарын 31 гарын үсэг зурсан.



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН САНААЧЛАГА ТББ



- 2010 оны 8 сарын 23-25-ны өдрүүдэд Санаачлага болон Австралийн Квийнсландын их сургуулийн Уул уурхайн нийгмийн хариуцлагын төв хамтран Оюу толгой ХХК-ийн ажилчид болон Өмнөговь аймгийн иргэний нийгмийн байгууллагын төлөөллийн 29 оролцогчийг хамруулсан “Уул уурхайн компаний нутгийн иргэдтэй харилцах харилцааг бэхжүүлэх нь” сэдэвт сургалтыг амжилттай зохион байгуулсан.
- 2010 оны 8 сарын 30-9 сарын 1-ний өдрүүдэд мөн Санаачлага болон Австралийн Квийнсландын их сургуулийн Уул уурхайн нийгмийн хариуцлагын төв хамтран уул уурхайн нийт 7 компаний 15 оролцогчийг хамруулсан “Уул уурхайн компаний нутгийн иргэдтэй харилцах харилцааг бэхжүүлэх нь” сэдэвт сургалтыг амжилттай зохион байгуулсан.
- 2010 оны 8 сарын 24-25, 2010 оны 09 сарын 02-03-ны өдрүүдэд Австралийн Квийнсландын их сургуулийн Санаачлагад хийсэн судалгаа явагдаж, УЗ гишүүдтэй уулзан Олон талт оролцоог хангаж уул уурхайн салбарт ажиллаж байгаа энэ Санаачлагын түүх нь ямар юм бэ? Одоо ямар шатанд явж байна, цаашид ямар амжилтанд хүрэх вэ? Гэсэн судалгааг явуулсан бөгөөд энэхүү судалгааны үр дүн 2011 оны нэгдүгээр сард ирэхээр хүлээгдэж байна.
- 2010 оны 9 сарын 3-ны өдөр Санаачлага болон Монгол Улсын Хөдөө аж ахуйн их сургууль, Нидерландын Вант Улсын Вагенигений их сургуультай хамтран “Уул уурхай ба бүс нутгийн эдийн засгийн бодлого” сэдэвт сургалтыг эрдэмтэд, төр, төрийн бус байгууллагууд, уул уурхайн компаниудын төлөөллийг хамруулж, уул уурхайн оновчтой менежментийг нэвтрүүлэх аргачлалаар санал солилцох үйл ажиллагааг зохион байгуулсан.
- Санаачлага болон ХУУ-н шалгуур үзүүлэлтийн талаарх танилцуулга, сургалтыг 2010 оны 11 сарын 25-ны өдөр УЗ гишүүн Г. Батсайхан болон Ажлыг алба хэвлэлийн хүрээлэнгийн эдийн засаг, уул уурхайн чиглэлээр бичдэг сэтгүүлчдэд зориулан хийсэн. Энэ чиглэлийн сургалтуудыг цаашид АНУ-ын хөгжлийн хөтөлбөрийн “Эдийн засгийн бодлогын өрсөлдөх чадвар төсөл” төсөлтэй хамтран зохион байгуулахаар төлөвлөж байна.
- Санаачлага нь Дэлхийн банк, АНУ-ын хөгжлийн хөтөлбөрийн “Эдийн засгийн бодлогын өрсөлдөх чадвар төсөл”, Канадын Олон улсын худалдаа, гадаад хэргийн газар, Квийнсландын их сургуулийн уул уурхайн нийгмийн хариуцлагын төвийн дэмжлэгтэйгээр 2010 оны 12 сарын 7,8-ны өдрүүдэд “Уул уурхай ба орон нутаг, нутгийн иргэдийн харилцаа” сэдэвт чуулга уулзалтыг зохион байгуулсан.

2.3 Зорилго III. Хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгоход нөлөөлөх

- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний хуулийг шинэчлэн боловсруулах Ажлын хэсгийн ахлагчаар Удирдах зөвлөлийн гишүүн Л. Долгормаа оролцож, Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас 2010 оны 3 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулсан “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний хууль”-ийн хэлэлцүүлэгт Санаачлагыг төлөөлөн Удирдах зөвлөлийн гишүүн Г. Батсайхан, Л. Батнасан, Б. Чинзориг нар оролцож, хуулийн төсөлд тодорхой санал өгсөн.
- Удирдах зөвлөлийн XIII хурлын шийдвэрээр 2010 оны 10 сард зохион байгуулахаар болоод байсан “Гол мөрний урсац бүрэлдэх эх, усан саны хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт үйл ажиллагаа явуулаагүй байх”



ТОГВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН САНААЧЛАГА ТББ



хуулийн төслийн хүрээнд оролцогч талуудын хэлэлцүүлэг хийх ажлыг зохион байгуулахыг УЗ-ийн даргын шийдвэрийн дагуу тодорхой бус хугацаанд хойшлуулсан.

2.4 Зорилго IV. Байгууллагын зохион байгуулалт, санхүүжилтийг бэхжүүлэх

Санаачлагыг бүтэц зохион байгуулалт, ур чадварын хувьд бэхжүүлэх зорилгоор хийгдсэн ажлууд

1. Санаачлагын Удирдах зөвлөл дэх иргэний нийгмийн болон үйлдвэрлэгчдийн төлөөллийг сонгох журам боловсруулагдан Удирдах зөвлөлөөр батлагдсан.
2. Санаачлагын хяналтын зөвлөлийн ажиллах журам боловсруулагдан Удирдах зөвлөлөөр батлагдсан.
3. Санаачлагын санхүүжилтийг зохицуулах журам боловсруулагдан Удирдах зөвлөлөөр батлагдсан.
4. “Хөрөнгө оруулалтын бодлогын стратегийн зөвлөгөө төсөл”-д зөвлөхөөр ирсэн Доктор Ханс Юрген Райтер ажлын албатай ярилцсаны дагуу “Байгууллагын хөгжил болон олон талуудтай хамтран ажиллах арга барилын талаар сургалт”-ыг Санаачлагын ажлын алба болон Удирдах зөвлөлийн гишүүдэд зориулан 2010 оны 10 сарын 1-ний өдөр хийсэн. Уг сургалтад Санаачлагын ажлын алба, УЗ-ийн гишүүн Д. Сүхбаатар, С. Хасар нар оролцсон.
5. 2010 оны 11 сарын 18-ны өдөр Санаачлага болон Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн хөтөлбөр, “Хөрөнгө оруулалтын бодлогын стратегийн зөвлөгөө төсөл”-ийн хамтын ажиллагааны хүрээнд Санаачлагын ажлын алба болон Удирдах зөвлөлийн гишүүдэд зориулан явуулж буй 2 дахь сургалтыг Доктор Юрген Шепер “Байгууллагын хөгжлийн төлөвлөлт, санхүүгийн төлөвлөлт, хөгжлийн хамтын ажиллагааны стратегийн төлөвлөлт” сэдвээр явуулсан болно. Уг сургалтад Санаачлагын Удирдах зөвлөлийн гишүүн Г. Батсайхан, Д. Сүхбаатар болон ажлын алба оролцсон.

Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн хөтөлбөр, “Хөрөнгө оруулалтын бодлогын стратегийн зөвлөгөө төсөл”-ийн хамтын ажиллагааны хүрээнд хийгдэж буй эдгээр үнэ төлбөргүй сургалтууд 2011 онд мөн үргэлжлэх бөгөөд ажлын алба энэхүү сургалтад оролцогч талуудыг хамруулах, тэдгээрийн хэрэгцээ шаардлагад нийцсэн сэдэв, агуулгыг бэлтгэх тал дээр хамтран ажиллах болсон болно. Түүнчлэн удирдах зөвлөлийн гишүүдээс санал аван тодорхой сэдэвүүдээр сургалт авах сонирхолтой байгаагаа гарган ГТХАН-д хүргүүлсэн болно.

6. 2010 оны 12 сарын 4,5 нд Удирдах зөвлөлийн хурлыг өргөтгөсөн байдлаар хийж удирдах зөвлөлийн гишүүд Санаачлагын стратеги болон үйл ажиллагаанд дүгнэлт хийсний дагуу Санаачлагын дүрэмд өөрчлөлт оруулах ажлын хэсгийг байгуулсан. Энэхүү ажлын хэсэг нь Удирдах зөвлөл дэх гишүүдийн тоог 21 хүртэл нэмэгдүүлэх, оролцогч талуудын тэнцвэртэй байдлыг хангах зорилготой нэмэлт өөрчлөлтүүдийг дүрэмд оруулахаар болсон.



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН САНААЧЛАГА ТББ



Санаачлагын санхүүжилтийг тогтворжуулах зорилгоор хийгдсэн ажлууд

- Санаачлагын санхүүжилтийн эх үүсвэрийг тогтвортой, хараат бус байлгах үүднээс олон улсын донор байгууллагууд болох АНУ-ын хөгжлийн хөтөлбөрийн “Эдийн засгийн бодлогын өрсөлдөх чадвар төсөл”, АНУ-ын Азийн сангийн Байгаль орчны хөтөлбөр, Дэлхийн Банк, Германы техник хамтын ажиллагааны нийгэмлэг, Канадын Олон улсын худалдаа, гадаад хэргийн газар Зүүн ази номхон далайн бүсийн орнуудын нийгмийн хариуцлагын төлөөх сүлжээтэй хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, шинээр эхлүүлэх ажлуудыг амжилттай хийж гүйцэтгэлээ.
- Мөн Санаачлагын оролцогч талын 1 болох үйлдвэрлэгч нарт Санаачлагыг таниулан, ойлгуулах, сурталчлах ажлыг тогтвортойгоор зохион байгуулж тэдэнд зориулсан бүтээгдэхүүн үйлчилгээ, түүнийг хүргэх механизмыг амжилттайгаар бий болгосон нь цаашид үйлдвэрлэгчдийн салбараас сан бүрдүүлэх боломжийг олгож байна.

Бусад сан бүрдүүлэхээр оролцсон төсөл хөтөлбөрүүд:

1. Оюу толгой төслийн урт хугацааны Соёлын өвийн хөтөлбөр хэрэгжүүлэхтэй холбоотой Зөвлөх үйлчилгээ үзүүлэх тендерийн шалгаруулалтанд Санаачлага Wardell-armstrong LLP болон Монголын Урлагийн Зөвлөлтэй хамтран оролцсон боловч тендерт шалгараагүй.
2. Оюу толгой төслийн урт хугацааны Эрүүл мэндийн хөтөлбөрт РАСТ төслөөс хамтарч оролцох тухай санал ирүүлсэнтэй холбоотойгоор уг тендерт Санаачлагын зүгээс хөндлөнгийн үнэлгээг хийхээр оролцсон боловч тендерт шалгараагүй.

3. ДҮГНЭЛТ

Санаачлагын ажлын алба үүсгэн байгуулагдснаас хойш даруй 2 жил 8 сар болсон байна. Өнгөрсөн 2010 онд Санаачлагын баг (Удирдах зөвлөл, ажлын алба) санхүүгийн хувьд бие даасан байгууллага болгохын тулд дотоод зохион байгуулалт, менежмент, тогтвортой үйл ажиллагаатай болгоход чиглэсэн ажлуудыг эхлүүлж заримыг нь хийж гүйцэтгэлээ. Мөн ХУУ-н шалгуур үзүүлэлтийн туршилтын төслийг эхлүүлэх, Санаачлагыг олон улсын түвшинд таниулах томоохон ажлуудын эхлэл суурийг тавьлаа.

Санаачлагын санхүүжилтийн хувьд 2010 онд Азийн сангийн “Ирээдүйгээ баталгаажуулах нь” хөтөлбөр дуусгавар болсонтой холбоотойгоор Азийн сангаас Санаачлагад өгч байсан үйл ажиллагааны санхүүжилт 2010 оны 9 сар хүртэл зогссон нь Санаачлагыг санхүүгийн хувьд бие даах, дан ганц санхүүжүүлэгчээс хамааралгүй байх, бусад оролцогч талуудаас сан бүрдүүлэн ажиллахад хүргэсэн томоохон сорилт байлаа.

2010 онд хүрсэн үр дүн болон цаашид анхаарах зүйлсийг дараах байдлаар гаргалаа.

3.1 Хүрсэн үр дүн



ТОГВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН САНААЧЛАГА ТББ



Байгууллагын үйл ажиллагаанд зайлшгүй хэрэгцээтэй баримт бичгүүд боловсруулагдсан

1. Байгууллагын харилцааны стратеги (шинэчлэгдэн боловсруулагдсан)
2. Санаачлагын Удирдах зөвлөл дэх иргэний нийгмийн болон үйлдвэрлэгчдийн төлөөллийг сонгох журам
3. Санаачлагын хяналтын зөвлөлийн ажиллах журам
4. Санаачлагын санхүүжилтийг зохицуулах журам

Олон улсын байгууллагуудтай бий болгосон хамтын ажиллагааны үр дүнд:

1. ХУУ-н шалгуур үзүүлэлтийн туршилтын төслийн эхлүүлэхээр болсон
2. Уул уурхайн компаниудын дунд компаний нийгмийн хариуцлага болон орон нутаг, нутгийн иргэдтэй харилцах чиглэлээр мэдлэг мэдээлэл солилцох сүлжээг байгуулахаар болсон
 - Санаачлага энэ сүлжээний зохион байгуулагч, чиглүүлэгч байгууллага байхаар шийдвэр гарсан.
 - Дэлхийн Банк болон Канадын элчин сайдын яамны Канадын Олон улсын худалдаа, гадаад хэргийн газар сүлжээг цаашид санхүүжүүлэн ажиллахаа мэдэгдсэн
 - Уул уурхайн компаниуд Сүлжээнд нэгдэн орж хамтран ажиллах мөн түүнчлэн сүлжээнээс зохион байгуулагдах сургалт, форумд төлбөр төлж оролцох, гишүүнчлэлийн төлбөртэй байна гэсэн шийдвэрийг дагахаа мэдэгдсэн
 - Форумын оролцогчид энэхүү сүлжээг санаачлагчид буюу зөвлөх бүлгээс Санаачлагатай цаашид хамтран ажиллах шийдвэр гаргасан. Энэхүү зөвлөх бүлэг нь сүлжээний цаашид ажиллах стратегийг Санаачлагатай хамтран боловсруулж, гүйцэтгэл болон санхүүжилтэнд дэмжлэг үзүүлэн ажиллана.
3. Санаачлага болон Германы техник хамтын ажиллаганы нийгэмлэгтэй стратегийн түншлэл байгуулан Санаачлагын харъяа ХУУ-н мэдээллийн төв байгуулахаар болсон. Бусад хамтын ажиллагааны боломжийг судалж байна.
4. Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн “Хөрөнгө оруулалтын бодлогын стратегийн зөвлөгөө төсөл”-ийн хамтын ажиллагааны хүрээнд хийгдэж буй үнэ төлбөргүй сургалтууыг 2011 онд мөн үргэлжлүүлэн зохион байгуулах болсон
5. Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн CIM хөтөлбөрийн хүрээнд ХУУн шалгуур үзүүлэлтийг хэрэгжүүлэх үйл явцад зөвлөгөө өгөн ажиллах герман эксперт 2011 оны эхний улиралд багтан ирэхээр болсон.
6. Зүүн ази номхон далайн бүсийн орнуудын нийгмийн хариуцлагын төлөөх сүлжээний (ANSA EAP) “Revenue Watch Institute” -ийн тусламжаар хэрэгжүүлэх олборлох салбарын иргэний нийгмийн байгууллагуудын нийгмийн хариуцлагыг бэжүүлэх 2 жилийн хөтөлбөрт оролцохоор саналаа илгээсэн. Одоогийн байдлаар энэхүү хөтөлбөрт Зүүн



ТОГВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН САНААЧЛАГА ТББ



өмнөд азийн 4 орон хамрагдах байсан бөгөөд Монгол улс буюу Санаачлага 5 дахь орон болон ороод байгаа болно.

7. Хэвлэлийн хүрээлэнгийн эдийн засаг, уул уурхайн чиглэлээр бичдэг сэтгүүлчдэд зориулсан сургалтыг АНУ-ын хөгжлийн хөтөлбөрийн “Эдийн засгийн бодлогын өрсөлдөх чадвар төсөл” хамтран хийхээр төлөвлөж байна.

3.2 Цаашид анхаарах зүйлс

1. Вэб хуудсыг англи хэлнээ хөрвүүлэн ажиллуулах.
2. Санхүүгийн эх үүсвэр мөн үйл ажиллагааны тоо өсөн нэмэгдэж буйтай холбогдуулан Байгууллагын үйл ажиллагааны болон ажилтнуудын хоорондын харилцан уялдааг чанд хангаж байх
3. Удирдах зөвлөлийг сан бүрдүүлэх үйл ажиллагаанд татан оролцуулах
4. Ажлын албыг чадавхижуулах, сургалтад хамруулах.
5. Удирдах зөвлөлийн гишүүд өөрсдийн байгууллагын зохион байгуулж буй сургалт, семинарт Санаачлагын ажлын албаныхныг үнэ төлбөргүйгээр болон хөнгөлөлттэй үнээр хамруулж байвал сайн байна.
6. Иргэний нийгмийн байгууллагуудад ялангуяа орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй иргэний нийгмийн байгууллага, иргэдийн бүлэг, төрийн бус байгууллагуудыг чадавхижуулах, тэдэнтэй хамтран ажиллах
7. Орон нутаг болон үндэсний хэмжээнд оролцогч талуудын хурлыг зохион байгуулах
8. Цаг үеийн тулгамдсан асуудлаар олон талуудын уулзалтыг зохион байгуулах
9. Төрийн яамд агентлагуудаас сан бүрдүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх тал дээр анхаарал хандуулж ажиллах.



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН САНААЧЛАГА ТББ



Хавсралт. 1

“Тогтвортой хөгжлийн төлөөх Хариуцлагатай уул уурхайн санаачлага” төрийн бус байгууллагын Удирдах зөвлөлийн 2010 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн хурлаар батлав.

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН САНААЧЛАГЫН САНХҮҮЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

Энэхүү журмын зорилго нь “Тогтвортой хөгжлийн төлөөх хариуцлагатай уул уурхайн санаачлага” ТББ-ын зорилгодоо хүрэхэд чиглэсэн үйл ажиллагааны санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хянан шалгахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Санаачлагын санхүүгийн эх үүсвэр

2.1. Санаачлагын дүрмэнд заасны дагуу Санаачлагын орлого нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:

- Удирдах зөвлөлийн гишүүд, зөвлөх болон ажилтнуудын хандив;
- Дэмжигч байгууллагууд, иргэдийн оюун санаа, үйл ажиллагааны оролцоогоор бүрдэх хандив, тусламж;
- Үндсэн үйл ажиллагаанаас олсон орлого;
- Төсөл хэрэгжүүлэх замаар гадаад, дотоодын байгууллага, хувь хүнээс олгосон хөрөнгө, тусламж, дэмжлэг;
- Төрийн байгууллагаас гэрээгээр гүйцэтгүүлэх ажлын санхүүжилт,
- Улсын төсвөөс олгосон мөнгөн хөрөнгө;
- Зээл, өвөөс олсон орлого;
- Монгол Улсын хуулиар хориглоогүй бусад эх үүсвэр зэрэг болно.

2.2. Төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшил зэрэг гол оролцогч талуудын тэгш оролцоог хангах үүднээс санаачлагын санхүүжилтийг гурван талын эх үүсвэрээс хэмжээг харгалзахгүй бүрдүүлнэ.

2.3. Санаачлага нь санхүүжүүлэгчидтэй санхүүжилтийг хэрхэн зарцуулах, тайлагнах талаар гэрээ байгуулан ажиллана.

Гурав. Санхүүжилтийг зарцуулах

3.1. Санаачлагын санхүүжилт нь байгууллагын зорилгод нийцсэн үйл ажиллагаанд зарцуулагдах бөгөөд ажлын алба нь түүний хэмжээ болон зориулалтыг тусгасан төслийг боловсруулан удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, батлуулна.



ТОГВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН САНААЧЛАГА ТББ



- 3.2. Санхүүжилтийг санаачлагын дүрмийн дагуу удирдах зөвлөлийн дарга, хяналтын зөвлөл болон санхүүжүүлэгчийн хяналтан дор Гүйцэтгэх захирал зүй зохистой, үр ашигтай захиран зарцуулна.

Дөрөв. Санхүүжилтыг тайлагнах

- 4.1. Ажлын алба санхүүгийн явц, эцсийн тайланг гэрээнд заасан хугацаанд Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөл болон санхүүжүүлэгчид холбогдох баримтуудын хамт танилцуулна.
- 4.2. Санхүүгийн тайланг хугацаанд нь холбогдох талуудад танилцуулах

Тав. Санхүүжилтийг хянан шалгах

- 5.1. Санаачлагын санхүүгийн үйл ажиллагаанд Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөл, санхүүжүүлэгч хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд хянан шалгах эрхтэй.
- 5.2. Санхүүгийн хяналт шалгалтын дүнг Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэж, хэрэв буруутай зүйл илэрвэл санаачлагын дүрэм, журмын дагуу тухайн этгээдэд хариуцлага тооцно.
- 5.3. Санхүүжилтийг зориулалтын бус хэрэгцээнд зарцуулсан тохиолдолд буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

Зургаа. Эрх, үүрэг

- 6.1. Санаачлагын ажлын алба нь дараах эрх, үүрэгтэй байна:
- 6.1.1. Удирдах зөвлөлийн хурлаар санхүүжүүлэгч болон санхүүгийн төсөв, төсөл, гэрээг хэлэлцүүлж батлуулах
 - 6.1.2. Санхүүжилтийг төсөл болон гэрээнд заасан зориулалтын дагуу зүй зохистой, үр ашигтай захиран зарцуулах
 - 6.1.3. Удирдах Зөвлөл, Хяналтын Зөвлөл болон санхүүжүүлэгчид санхүүжилттэй холбоотой баримт материалуйг гаргаж өгөх
 - 6.1.4. Санхүүжүүлэгчид санхүүжилтийн журмыг урьдчилан танилцуулах
- 6.2. Санхүүжүүлэгч нь дараах эрх, үүрэгтэй байна:
- 6.2.1. Санхүүжилтийн эх үүсвэрийг зөвхөн өөрийн эрх ашигт нийцүүлэн зарцуулах шаардлага тавихгүй байх
 - 6.2.2. Санхүүжилтийн журмыг баримтлан үйл ажиллагаа явуулах
 - 6.2.3. Санхүүжилтийн зарцуулалтад хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд хяналт шалгалт хийх санал, хүсэлт гаргах



6.2.4. Хамтарсан ажлын хэсэг болон хөндлөнгийн хяналт шалгалтаар санхүүгийн эх үүсвэрийг буруу зарцуулсан нь тогтоогдсон тохиолдолд санхүүжилтийг зогсоох эрхтэй.



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН САНААЧЛАГА ТББ



Хавсралт.2

“Тогтвортой хөгжлийн төлөөх Хариуцлагатай уул уурхайн санаачлага” төрийн бус байгууллагын Удирдах зөвлөлийн 2010 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн хурлаар батлав.

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН САНААЧЛАГЫН ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь Тогтвортой хөгжлийн төлөөх хариуцлагатай уул уурхайн Санаачлага төрийн бус байгууллагын (цаашид Санаачлага гэх) Хяналтын зөвлөлийн дарга, гишүүдийг сонгох, чөлөөлөх болон хяналтын зөвлөлийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Хяналтын зөвлөл нь Төрийн бус байгууллагын тухай Монгол Улсын хууль, Санаачлагын дүрэм болон энэхүү журам, холбогдох хууль, тогтоомжийг мөрдлөг болгон ажиллана.
- 1.3. Хяналтын зөвлөлийг Санаачлагын дүрмийн дагуу гурван талыг төлөөлсөн дэмжигчдээс 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулна.
- 1.4. Хяналтын зөвлөл нь Хариуцлагатай уул уурхайн тунхагийн зарчмуудын болон Санаачлагын дүрмийн хэрэгжилт, Удирдах зөвлөлийн гишүүдийн ёс зүй, санхүүгийн зохистой үйл ажиллагааг хангахад чиглэгдэнэ. Хяналт, шалгалтын дүнг Хяналтын зөвлөл шаардлагатай гэж үзвэл Удирдах зөвлөлийн хурал болон дэмжигчдэд мэдэгдэнэ.
- 1.5. Хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнд Удирдах зөвлөлийн гишүүн орохгүй бөгөөд 2 жил тутам шинэчлэгдэж байна.

Хоёр. Хяналтын зөвлөлийн гишүүдэд нэр дэвшүүлэх

- 2.1. Оролцогч гурван талын дэмжигчдээс Хяналтын зөвлөлийн гишүүнээр тус бүр нэг нэр дэвшигчийг дэвшүүлнэ.
- 2.2. Санаачлагын хяналтын зөвлөлийн гишүүнд эдийн засаг, бизнес, төсөв, санхүү, менежмент, эрх зүйн чиглэлээр зохих хэмжээний мэдлэгтэй хүнийг нэр дэвшүүлнэ.
- 2.3. Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдээс бүрдүүлэх материал:
 - 2.3.1. Анкет /биеийн байцаалт/;
 - 2.3.2. Боловсрол, эрдмийн зэрэг, цолны диплом, гэрчилгээний хуулбар;
 - 2.3.3. Одоогийн ажиллаж байгаа байгууллагын тодорхойлолт;
 - 2.3.4. Иргэний үнэмлэхийн хуулбар;
 - 2.3.5. Нэр дэвшигчийн зүгээс Хяналтын зөвлөлийн гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн зөвшөөрөл;
 - 2.3.6. Дэмжигч байгууллагын санал, дүгнэлт.



ТОГВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН САНААЧЛАГА ТББ



- 2.4. Нэр дэвшигч бүрдүүлсэн материалаа тогтоосон хугацаанд Санаачлагын Ажлын албанд ирүүлнэ.

Гурав. Нэр дэвшигчдээс сонгон шалгаруулж, хяналтын зөвлөлийн дарга, гишүүдийг сонгох, чөлөөлөх

- 3.3. Санаачлагын дэмжигч байгууллагын хурлаар хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг энэхүү журмын 2 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан эсэхээр дүгнэлт гаргаж, нэр дэвшигчдийн талаар товч танилцуулга хийнэ. Нэр дэвшигчид хуралдаанд биечлэн оролцох бөгөөд дэмжигч гишүүдийн асуултад хариулт өгнө.
- 3.4. Хяналтын зөвлөлд үйлдвэрлэгчид, төрийн болон иргэний нийгмийн байгууллагуудыг төлөөлсөн тус бүр нэг гишүүн сонгогдоно.
- 3.5. Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийг Санаачлагын дэмжигчдийн хурлаар хэлэлцэж батлана. Танилцуулга хийгдэж, асуулт, хариулт дууссаны дараа нэр дэвшигчдээс хяналтын зөвлөлийн гишүүнийг сонгох саналыг нууц санал хураалтаар шийдвэрлэнэ. Нууц санал хураалтаар хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг хяналтын зөвлөлийн гишүүнд сонгогдсонд тооцно.
- 3.6. Хяналтын зөвлөлийн даргыг Хяналтын зөвлөлийн гишүүд өөрсдөө сонгоно.
- 3.7. Хяналтын зөвлөлийн дарга, гишүүдийн бүрэн эрхийн хугацаа сонгогдсон өдрөөс эхлэн 2 жил байна.
- 3.8. Хяналтын зөвлөлийн дарга, гишүүд дахин нэг удаа дараалан сонгогдон ажиллаж болно.
- 3.9. Хяналтын зөвлөлийн үйл ажиллагаа, хуралдааны бэлтгэл хангах, шийдвэр биелүүлэх ажиллагаа зэрэгт Санаачлагын Ажлын алба дэмжлэг үзүүлнэ.

Дөрөв. Хяналтын зөвлөлийн бүтэц, зохион байгуулалт

- 4.1. Хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хурал байна.
- 4.2. Ээлжит хурлыг жилд 2-оос доошгүй удаа хийнэ.
- 4.3. Ээлжит бус хурлыг дарга, Хяналтын зөвлөлийн гишүүдийн санаачлагаар зарлан хуралдуулна.
- 4.4. Хяналтын зөвлөлөөр хэлэлцэх асуудал болон хурлын материалыг хурал болох өдрөөс 5-оос доошгүй хоногийн өмнө Ажлын албанаас бичгээр тараана.
- 4.5. Хяналтын зөвлөлийн дарга хурлыг удирдана.
- 4.6. Хяналтын зөвлөлийн хуралд гишүүд бүрэн ирсэн тохиолдолд ирц хүчинтэйд тооцогдоно. Хуралд оролцож буй гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ. Хурлаар хэлэлцсэн асуудлаар тэмдэглэл хөтөлж, гарын үсгийг оролцсон гишүүд бүгд зурж баталгаажуулна.
- 4.7. Хурлаас шийдвэр, зөвлөмж гаргана.

Тав. Хяналтын зөвлөл, түүний дарга, гишүүдийн эрх, үүрэг

Хяналтын Зөвлөл нь дараах эрхийг хэрэгжүүлнэ.



ТОГВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН САНААЧЛАГА ТББ



- 5.1. Холбогдох хуулийн дагуу мөн Дэмжигч гишүүдээс ирүүлсэн саналын дагуу Санаачлагын санхүүгийн үйл ажиллагааны аудит, Удирдах зөвлөлийн үйл ажиллагаатай, тэдний гишүүдийн ёс зүйтэй холбоотой гарсан саналд хяналт шалгалт хийхээс гадна тухайн санхүүжүүлэгч дангаараа болон Хяналтын зөвлөлтэй хамтарсан ажлын хэсэг байгуулан санхүүгийн шалгалт хийх эрхтэй.
- 5.2. Хяналтын зөвлөл шалгалтын зорилгоор холбогдох баримт, мэдээ, материалыг Удирдах зөвлөлийн дарга, гүйцэтгэх захирал нараас гаргуулж авах эрхтэй.
- 5.3. Хяналтын зөвлөлийн гишүүд Санаачлагын бүх шатны хуралд зөвлөх эрхтэйгээр оролцож болно.
- 5.4. Хяналтын зөвлөлийн дарга нь Хяналтын зөвлөлийн үйл ажиллагааг удирдан зохицуулах, гишүүддээ ажил үүргийг нь хуваарилан хариуцуулах, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, гарсан шийдвэр, зөвлөмжийг Санаачлагын Удирдах зөвлөлд хүргүүлэх эрхтэй.

Хяналтын зөвлөлийн дарга, гишүүд нь дараах үүргийг хүлээнэ.

- 5.5. Журамд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ хөндлөнгийн этгээдийн нөлөөнд автахгүй байх, эрхээ хувийн зорилгод ашиглахгүй байх зарчмыг баримталж хяналтын үүргээ бодитой хэрэгжүүлэх;
- 5.6. Ажил үүргийн хүрээнд мэдсэн төр, байгууллага, хувь хүний нууцыг задруулахгүй байх;
- 5.7. Хяналтын зөвлөлийн хуралд санал дүгнэлт гаргах;
- 5.8. Хяналтын зөвлөлийн гишүүний үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагаанд оролцохдоо Удирдах зөвлөлийн зүгээс дэмжлэг туслалцаа авах.

Зургаа. Хяналтын зөвлөлийн үндсэн зорилго, үйл ажиллагааны чиглэл

- 6.1. Хяналтын зөвлөлийн үйл ажиллагаа нь Хариуцлагатай уул уурхайн тунхагийн зарчмуудын болон Санаачлагын дүрмийн хэрэгжилт, Удирдах зөвлөлийн гишүүдийн ёс зүй, санхүүгийн зохистой ажиллагааг хангахад чиглэгдэнэ.
- 6.2. Хяналтын зөвлөл нь зорилгоо хэрэгжүүлэхийн тулд дор дурдсан үндсэн үйл ажиллагаа явуулах эрхтэй.
 - 6.2.1. Удирдах зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих;
 - 6.2.2. Санаачлагын санхүү, аж ахуйн үйл ажиллагаа, менежмент, төсвийн төсөл, санхүүгийн жилийн тайланд дүгнэлт хийж, Дэмжигч гишүүдэд мэдээллэх
 - 6.2.3. Хөрөнгө оруулалт, төсөв, хүний нөөцийн бодлогод нөлөөлөхүйц санхүүгийн гэрээ, хэлэлцээрийг бусад аж ахуйн нэгж, байгууллага, иргэнтэй байгуулах асуудлаар санал боловсруулж, Удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэх
 - 6.2.4. Удирдах зөвлөлийн гишүүдийн ёс зүйтэй холбоотой гарсан саналд шалгалт хийх, мэдээллэх
 - 6.2.5. Удирдах зөвлөл, Ажлын албанаас гаргасан шийдвэр, түүнийг хэрэгжүүлэх ажиллагаа нь нийтлэг ёс зүйд нийцсэн, байгууллагын үнэт зүйлтэй харшлаагүй эсэхийг шалган тогтоож холбогдох арга хэмжээг санал болгох



- 6.2.6. Хяналтын зөвлөл шаардлагатай тохиолдолд гадаад дотоодын аудитын байгууллагыг сонгон шалгаруулж, 2 жилд нэг удаа Санаачлагын санхүүд аудит хийлгэх.
- 6.2.7. Шаардлагатай гэж үзвэл Санаачлагын санхүүд хэсэгчилсэн болон давтан аудит хийлгэж болно.

Энэ бүтэцтэй холбоотойгоор Дүрэмд орох өөрчлөлт

- Дэмжигч гишүүдийн хурлын талаар заалт нэмэх түүний журмыг боловсруулах
- Удирдах зөвлөлийн гишүүний ёс зүйн баримт бичиг боловсруулах

Энэ бүтэцтэй холбоотойгоор шинээр боловсруулж буй журамд орох өөрчлөлт

- *Санаачлагын дүрмийн “5.1. Удирдах зөвлөл 15 доошгүй гишүүнтэй байна. Санаачлагыг анх үүсгэн байгуулсан, түүний тунхаг, дүрмийг боловсруулан гаргахад оролцсон хүмүүс эхний удаад Удирдах зөвлөлийн гишүүн байх эрхтэй” гэжээ. тэгвэл дараагын удаад УЗ гишүүнийг сонгох тохиолдолд шинэ боловсруулсан журмын дагуу 3 талын төлөөлөл бүрт гишүүн авахдаа УЗ санал болгож, УЗ сонгож авах бус дэмжигч гишүүд нь өөрсдөө хурлаараа сонгодог байх*



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН САНААЧЛАГА ТББ



Хавсралт.3

“Тогтвортой хөгжлийн төлөөх Хариуцлагатай уул уурхайн санаачлага” төрийн бус байгууллагын Удирдах зөвлөлийн 2010 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн хурлаар батлав.

ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГА БОЛОН ҮЙЛДВЭРЛЭГЧДИЙН ТӨЛӨӨЛЛӨӨС УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНИЙГ СОНГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь Хариуцлагатай уул уурхайн Тунхагт (*цаашид Тунхаг гэх*) нэгдэн орсон, тус Санаачлагын эрхэм зорилго, зорилт, зарчмуудыг дагаж мөрдөн ажиллах иргэний нийгмийн байгууллагууд болон үйлдвэрлэгчдийн төлөөллийг “Тогтвортой хөгжлийн төлөөх Хариуцлагатай уул уурхайн Санаачлага” төрийн бус байгууллагын (*цаашид Санаачлага гэх*) Удирдах зөвлөлийн (*цаашид УЗ гэх*) гишүүнээр сонгоход оршино.
- 1.2. Төлөөлөх чадвартай УЗ-ийн гишүүн нь Санаачлагын зарчим, үнэт зүйлсийг үйл ажиллагаандаа даган мөрдөж, Санаачлагын хүрэн дэх хамтын ажиллагаа, зорилгод нийцсэн үйл ажиллагааны хэрэгжилтэнд хүндэтгэлтэй, шударга, хараат бус, ашиг сонирхлын зөрчилгүй байх зарчмыг баримтлан ажиллах ба Санаачлагад ажиллах хүсэл эрмэлзэл, зохих туршлага, чадварыг эзэмшсэн байх нийтлэг шаардлага тавигдана.
- 1.3. Иргэний нийгмийн байгууллага болон үйлдвэрлэгчдийн төлөөллөөс УЗ-ийн гишүүнийг сонгох үйл ажиллагаанд Санаачлагын дүрэм, энэхүү журмыг удирдлага болгон хэрэгжүүлнэ.
- 1.4. УЗ-ийн гишүүнийг сонгох үйл ажиллагаанд ил тод, нээлттэй, хараат бус, шударга байх зарчмыг баримтлана.
- 1.5. Иргэний нийгмийн төлөөлөлд байгаль хамгаалал, хүний аюулгүй байдлыг баталгаажуулах, хөдөлмөр хамгаалал, уул уурхай, геологийн судалгаа шинжилгээ, соёлын өв хамгаалал, нөхөн сэргээлт зэрэг чиглэлээр хариуцлагатай уул уурхайг бий болгох, үйл ажиллагаа явуулж буй иргэдийн эвсэл хөдөлгөөн, мэргэжлийн болон дагнасан үйл ажиллагаатай ТББ, холбогдох олон улсын байгууллагуудын төлөөлөгчид багтана.
- 1.6. Үйлдвэрлэгчдийн төлөөлөлд олборлох үйлдвэрлэлийн салбарт бизнесийн зорилгоор уул уурхай геологийн хайгуул, ашиглалт, бусад холбогдох үйл ажиллагааг явуулдаг компани, ААН-ийн төлөөлөл, тэдгээрийг төлөөлөх эрх бүхий мэргэжлийн эвсэл, холбоодын төлөөлөгчид багтана.

Хоёр. Удирдах зөвлөлийн гишүүнээр нэр дэвшигчдэд тавигдах шаардлага



- 2.1. УЗ-ийн гишүүнд сонгогдох нэр дэвшигчдэд Санаачлагын УЗ-д эзлэх Иргэний нийгмийн байгууллагууд болон үйлдвэрлэгчдийн төлөөллийн бүлгийн доторхи олон талын төлөөллийн тэнцвэртэй оролцоог хангах шалгуур, төлөөллийн байгууллага нь Тунхагт нэгдсэн орсон байх гэсэн ерөнхий шаардлага тус тус тавигдана.
- 2.1.1. Иргэний нийгмийн байгууллагаас нэр дэвшигчийн хувьд дараахь шаардлага тавигдана:
- нэр дэвшигч нь мэргэжлийн мэдлэг, ур чадвар, туршлагын хувьд салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн, ёс зүйтэй байх;
 - төлөөлж буй байгууллага нь Тунхагт тусгагдсан зорилт, зарчмуудыг хэрэгжүүлэх талаар бодитой үйл ажиллагаа явуулсан байх;
 - төлөөллийн байгууллагын үйл ажиллагаа, түүний үр дүн (*авч хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн үр дүн, хамарсан хүрээ, үйл ажиллагааны тайлан гэх мэт*) ил тод байх;
- 2.1.2. Үйлдвэрлэгчдийн төлөөллийн байгууллагаас нэр дэвшигчийн хувьд дараахь шаардлага тавигдана:
- нэр дэвшигч нь уул уурхайн салбарын үйлдвэрлэл, судалгаа, үнэлгээний эсвэл энэ чиглэлийн төлөөллийн төрийн бус байгууллагад 3-аас доошгүй жил ажилласан мэргэжлийн туршлага, чадвартай байх;
 - төлөөлж буй байгууллага нь Тунхагт тусгагдсан зорилт, зарчмуудыг хэрэгжүүлэх талаар бодитой үйл ажиллагаа явуулдаг байх;
 - үйлдвэрлэгчдийн төлөөллийн байгууллага нь үйл ажиллагаагаараа Монгол Улсад мөрдөгдөж буй холбогдох хууль тогтоомж болон бусад олон улсын гэрээ хэлэлцээрийг чанд сахин мөрддөг байх (*байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль хамгаалах төлөвлөгөө, тайлан, хайгуулын ажлын төлөвлөгөө, тайлан гэх мэт*);
- 2.1.3. *Батсайхан гишүүн санал: Төрийн төлөөлөл нь ... байна гэсэн өгүүлбэр оруулах*

Гурав. Удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох

- 3.1. УЗ-ийн гишүүнийг сонгох үйл ажиллагаа нь нэр дэвшүүлэх, сонгон шалгаруулах, нэр дэвшигчийг батлах гэсэн гурван үе шаттай байна.
- 3.2. УЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх үйл явц дараахи үе шатаас тогтоно. Үүнд:
- 3.2.1. УЗ-ийн хурлаар УЗ-ийн гишүүнийг шинээр сонгох болон УЗ-д багтах иргэний нийгмийн байгууллага, үйлдвэрлэгчдийн нэг нэг төлөөлөлөөс бүрдсэн УЗ-ийн даргаар ахлуулсан сонгон шалгаруулах ажлын хэсгийг байгуулах шийдвэр тус тус гарна.
- 3.2.2. УЗ-ийн гишүүнийг шинээр сонгох УЗ-ийн шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын 5 хоногийн дотор Санаачлагын ажлын албанаас тухайн бүлэгт хамаарах Тунхагт нэгдсэн орсон гишүүн байгууллагуудад УЗ-ийн шийдвэрийг энэхүү журмын хамт хүргүүлнэ.

- 3.2.3. Тунхагт нэгдсэн орсон гишүүн байгууллагаас нэр дэвшигч нь УЗ-ийн шийдвэр гарсанаас хойш ажлын 15 хоногийн дотор нэр дэвшихэд шаардагдах бичиг баримтыг бүрдүүлж Санаачлагын ажлын албанд хүргүүлнэ. УЗ-ийн гишүүнд нэр дэвшигч нь дараах баримтыг бүрдүүлнэ:
- нэр дэвшигчийн товч намтар;
 - төлөөлөх байгууллагын болон хамтран ажилладаг 2-оос доошгүй байгууллагаас гаргасан ажил байдлын тодорхойлолт;
 - энэхүү журмын 2.1-т заасан төлөөллийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой баримтууд, шаардлагатай гэж үзсэн бусад холбогдох бичиг баримтууд;
 - иргэний үнэмлэхийн хуулбар;
- 3.3. Нэр дэвшигчийг сонгон шалгаруулах үйл явц дараахи үе шатаас тогтоно. Үүнд:
- 3.3.1 Нэр дэвшигчид баримт бүрдүүлж өгсөн эцсийн хугацаанаас хойш ажлын 5 хоногийн дотор УЗ-өөс томилогдсон Сонгон шалгаруулах ажлын хэсэг хуралдаж нэр дэвшигчдийн бүрдүүлсэн бичиг баримтыг хянан нягталж энэхүү журмын 2.1-д заасан нэр дэвшигчдэд тавигдах шаардлагыг хангаж буй эсэхийг тогтоож шийдвэр гаргана.
- 3.3.2 Сонгон шалгаруулах ажлын хэсгийн гаргасан шийдвэрийг ажлын алба нэр дэвшигчдэд ажлын 3 хоногийн дотор мэдээллэнэ.
- 3.3.3 Сонгон шалгаруулах ажлын хэсгийн шийдвэр гарснаас хойш ажлын 15 хоногийн дотор УЗ-ийн дарга Тунхагт нэгдсэн орсон Иргэний нийгмийн байгууллагууд болон үйлдвэрлэгчдийн төлөөллийн бүлгийн хуралдааныг товлон зарлах ба Санаачлагын ажлын алба хуралдааныг зохион байгуулна.
- 3.3.4 Тунхагт нэгдсэн орсон тухайн бүлэгт хамаарах нийт гишүүн байгууллагын төлөөллийн 34-өөс дээш хувь нь ирсэн тохиолдолд Бүлгийн хуралдааныг хүчин төгөлдөр гэж тооцно. Бүлгийн хуралдааныг УЗ-ийн дарга удирдан явуулах ба тооллогын ажлыг Сонгон шалгаруулах ажлын хэсгийн гишүүд гүйцэтгэнэ.
- Г. Уранцоож гишүүн санал: 3 талын төлөөллөөс нэг нэг хүн л ирсэн бол батлахад хүчинтэй гэж үзэхэд болно. Харин талуудыг төлөөлөн ирж буй гишүүн өөрийн талын гишүүдтэй санал солилцсон байвал сайн. Үүнд ажлын алба дэмжлэг үзүүлэх.*
- 3.3.5 Бүлгийн хуралдаанаар Сонгон шалгаруулах ажлын хэсгийн шийдвэрээр тэнцсэн, энэхүү журмын 2.1.-д заасан шаардлагыг хангасан нэр дэвшигчдийг хэлэлцэн, нээлттэй санал хураах замаар хуралд оролцогчдын энгийн олонхийн саналаар УЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийг сонгоно. Бүлгийн хуралдаанаар УЗ-ийн гишүүний нэг орон тоон дээр энгийн олонхийн санал авсан 2 хүртэл тооны нэр дэвшигчийн нэрийг дэвшүүлж болно.
- 3.3.6 Хуралдааны тэмдэглэл, гарсан шийдвэрийг ажлын алба хөтлөн явуулах ба шийдвэрт УЗ-ийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.
- 3.4. УЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийг УЗ-ийн ээлжит хуралдаанаар хэлэлцэж батална.



ТОГВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН САНААЧЛАГА ТББ



- Батбаяр, Уранцоож гишүүн санал: *УЗ нь шууд л баталгаажуулна гэсэн ганц өгүүлбэр байх хэрэгтэй /тангараг өргүүлнэ гэдэг шиг/. Үүнд:*
- 3.4.1. УЗ-ийн дарга нэр дэвшигчийн талаар товч танилцуулга хийнэ.
 - 3.4.2. УЗ-ийн гишүүдэд 3.2.3.-д заасан нэр дэвшигчийн бүрдүүлсэн баримт болон Бүлгийн хуралдааны шийдвэрийг урьдчилан тараасан байна.
 - 3.4.3. УЗ-ийн гишүүд нэр дэвшигчийн талаар Санаачлагын дүрмийн дагуу хэлэлцэж УЗ-ийн гишүүнээр батлана.
 - 3.4.4. Санаачлагын УЗ-ийн гишүүнээр сонгогдсон нэр дэвшигчдэд УЗ-ийн гишүүний үнэмлэх олгоно.
 - 3.4.5. Нэр дэвшигч нь Санаачлагын УЗ-ийн хурлаар батлагдаагүй тохиолдолд УЗ-ийн гишүүнийг сонгох үйл ажиллагааг энэхүү журмын дагуу дахин явуулна.
- 3.5. Санаачлагын Ажлын алба нь УЗ-ийн гишүүнийг сонгох үйл ажиллагааг цаг хугацаанд шуурхай зохион байгуулах үүрэгтэй (*сонгон шалгаруулах ажлын хэсгийн ажилд туслах; бүлгүүдийн хурлын зар хүргэх; сонгон шалгаруулах, нэр дэвших үйл ажиллагааг хөнгөвчлөх баримт бичиг, маягтыг бэлтгэх, боловсруулах; хурлын өрөө, техник хэрэгслийг бэлэн байлгах; хурлын тэмдэглэл хөтлөх гэх мэт*).

Дөрөв. Бусад зүйл

- 4.1. УЗ-ийн гишүүнийг сонгохтой холбоотой гарах санхүүгийн зардлыг Санаачлагын дүрмийн хүрээнд шийдвэрлэж хэрэгжүүлнэ.



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН САНААЧЛАГА ТББ



Хавсралт. 4

Тогтвортой хөгжлийн төлөөх хариуцлагатай уул уурхайн санаачлага Америк нэгдсэн улсын “Азийн Сантай” 2011 оноос 2014 онд хамтран ажиллах стратеги төлөвлөгөө

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Хариуцлагатай уул уурхайн Санаачлагын байгуулагдсан болон үйл ажиллагаагаа явуулж буйн шалтгаан/ зорилго нь Монгол улсад хариуцлагатай уул уурхайн (цаашид ХУУ-н гэх) механизмыг бий болгож түүгээрээ дамжуулан уул уурхайн салбар дахь оролцогч талуудыг (төр, нутгийн иргэд, иргэд-иргэний нийгмийн төлөөлөл, үйлдвэрлэгчид) хийж буй үйлдэлдээ төдийгүй байгаль орчны өмнө хариуцлага хүлээдэг, бие биенийхээ эрхийг дээдлэн, оролцоог нь хүлээн зөвшөөрдөг механизмыг төлөвшүүлэх юм.

Энэхүү зорилгодоо хүрэхийн тулд Оролцогч талуудын хэлэлцэж баталсан ХУУ-н 8 зарчмыг хэрэгжүүлэхийн тулд монгол улсад төдийгүй олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шалгуур үзүүлэлттэй болж, уул уурхайн компаниудын үйл ажиллагааг үнэлж дүгнэх, санал, зөвлөмж өгч байх, шаардлага гарвал шүүмжлэх, үйл ажиллагаагаа сайжруулахад нь дэмжин ажиллах механизмтай болох юм.

Нөгөөтэйгүүр уул уурхайн үйлдвэрлэлийн салбар Монгол улсын хөгжлийн томоохон салбарын нэгд тооцогдож байгаагийн хувьд энэ салбарын хөгжил хариуцлагатай байж Монгол улсын иргэн бүрт үр өгөөжөө өгдөг байх нь хамгаас чухал юм.

Монгол Улсад ХУУ-г төлөвшүүлэх зорилгоор Санаачлага оролцогч талуудын оролцоотойгоор ХУУ-н тодорхойлолт, түүний найман зарчмыг боловсруулан эдгээр зарчмуудыг хэрэгжүүлэх шалгуур үзүүлэлтүүдийг, аргачлалын хамтаар эхний байдлаар боловсруулаад байна.

Иймд ХУУ-н найман зарчмын шалгуур үзүүлэлтийг уул уурхайн зарим компаниуд дээр туршиж үзэх, Уул уурхайн компаниудыг үнэлэн рейтинг тогтоох бэлтгэлийг хангах, ХУУ-н шалгуур үзүүлэлт, аргачлалыг оролцогч талуудаар хэлэлцүүлж батлуулах, ХУУ-н шалгуур үзүүлэлтээр уул уурхайн компаниудыг үнэлэх, зөвлөмж гаргах шаардлагатай байна.



ТОГВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН САНААЧЛАГА ТББ



ЕРӨНХИЙ ЗОРИЛГО: “МОНГОЛ УЛСАД ХУУ-Г ТӨЛӨВШҮҮЛЭХ”

Энэхүү зорилгодоо хүрэхийн тулд дараах 4 чиглэлийн хүрээнд ажиллана.

Чиглэл 1

Монгол улсад ХУУ-н зарчмууд, шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулах, хэрэгжүүлэх замаар ХУУ-г төлөвшүүлэх

Чиглэл 2

Төр, иргэний нийгэм, үйлдвэрлэгчидээс бүрдсэн оролцогч талуудын хүрээг өргөжүүлэх, үйл ажиллагааны механизмыг боловсронгуй болгох, уулзалтуудыг тогтмолжуулах

Чиглэл 3

ХУУ-н сургалт, судалгааны багийг байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулах ба олон нийттэй харилцах үйл ажиллагааг идэвхижүүлэх замаар ХУУ-н ойлголт, зарчим, түүний хэрэгжилтийг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх

Чиглэл 4

Байгууллагын бүтэц, үйл ажиллагааны чадавхийг сайжруулах/бэхжүүлэх



**ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ
ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН
САНААЧЛАГА ТББ**



Зорилго	Зорилт	Үр дүн	Үйл ажиллагаа	
Чиглэл 1				
<p>Зорилго: Монгол улсад ХУУ-г төлөвшүүлэх хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлснээр Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компаниудын хариуцлагын түвшинг тогтоон, дүн шинжилгээ хийсний үндсэн дээр уул уурхайн салбар дахь оролцогч талуудын гүйцэтгэх үүрэг хариуцлагыг нарийвчлан тодорхойлж, олон нийтэд ил тод мэдээлэх замаар ХУУ-г төлөвшүүлэх үндэс суурийг Монгол Улсад шинээр бий болгоход оршино.</p> <p>Үр дүн: Уул уурхайн салбар дахь оролцогч талуудын гүйцэтгэх үүрэг хариуцлагыг нарийвчлан тодорхойлно. Хөтөлбөрийн үр дүнд үйлдвэрлэгчдийн үйл ажиллагааг бодитой баримтаар</p>	1	ХУУ-н найман зарчмын шалгуур үзүүлэлтийг уул уурхайн зарим компаниуд дээр турших	<p>Шалгуур үзүүлэлтүүдийн саналыг уул уурхайн компаниудад танилцуулж, турших компаниудыг сонгох</p> <p>Судалгааны баг нь холбогдох газруудаас мэдээллийг цуглуулж газар дээр нь туршилтыг хэрэгжүүлэх</p> <p>Туршилтын үр дүнг дүгнэн нэгтгээд Удирдах зөвлөлд танилцуулах</p>	
	2	ХУУ-н шалгуур үзүүлэлт, аргачлал, туршилтын үр дүнг оролцогч талуудаар хэлэлцүүлэх	Оролцогч талуудын 2 удаагийн хурлыг зохион байгуулж, саналыг нэгтгэн авна.	<p>ХУУ- шалгуур үзүүлэлтийг оролцогч талуудаар хэлэлцүүлэх</p> <p>ХУУ-н шалгуур үзүүлэлтийг дүгнэх аргачлал болон туршилтын үр дүнг оролцогч талуудад танилцуулж хэлэлцүүлэх</p>
	3	ХУУ-н шалгуур үзүүлэлтийн туршилтын үр дүн, хэлэлцүүлгийн саналыг тусган эцэслэн боловсруулах	Компаниудын хариуцлагын түвшинг тогтоох шалгуур үзүүлэлт, үнэлэх аргачлалын хамтаар бэлэн болно.	<p>Судалгааны баг шалгуур үзүүлэлтийн туршилтын үр дүн, хэлэлцүүлгээс гарсан саналыг нэгтгэн боловсруулах</p> <p>ХУУ-н үнэлж, дүгнэх гарын авлага бэлтгэн гаргаж, оролцогч талуудад хүргүүлэх</p>



**ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ
ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН
САНААЧЛАГА ТББ**



<p>үнэлэх боломж бүрдэж, нэг талаас үйлдвэрлэгчид өөрийн үйл ажиллагааг бодитой сурталчлах, уул уурхайн үйлдвэрлэлийг хариуцлагатай байлгахын тулд юу хийх шаардлагатайгаа мэдэх бололцоо нээгдэх ба нөгөө талаас оролцогч талууд үйлдвэрлэгчдэд нөлөө үзүүлэх боломж, цар хүрээ талуудын нийтлэг эрх ашгийг “харах” чадвар нэмэгдэнэ. Ингэснээр монголын хөрсөн дээр буусан, уул уурхайн хариуцлагатай үйл ажиллагааны өөрийн туршлага хуримтлагдаж ХУУ-н Монгол загвар бий болно.</p>	4	Уул уурхайн компаниудыг үнэлэн, хариуцлагын түвшинг тогтоож, олон нийтэд мэдээлэх	Уул уурхайн компаниудын хариуцлагын түвшин тодорхойлогдож, компаниуд хэрхэн хариуцлагатай үйл ажиллагаа явуулах талаар тодорхой мэдлэгтэй болно.	<p>Уул уурхайн үйл ажиллагаа эрхэлдэг компаниудын хариуцлагын түвшинг тогтоохын тулд шалгуур үзүүлэлтийг дүгнэх мэдээллийг авах эх үүсвэрүүдийг тогтоох</p> <p>Мэдээллийг авах төрийн байгууллагуудтай хамтран ажиллаж, уул уурхайн компаниудын талаар тэдгээрийн мэдээллийг нэгтгэн авдаг бүтцийг (БОАЖЯ, ЭБЭХЯ, МХЕГ, ҮСТГ, АМГ, НХХЯ, ОУИТБС)/хүснэгтийг/ хариуцлагын зарчмын шаардлагад нийцүүлж боловсронгуй болгох</p> <p>Дээрх байгууллагуудтай мэдээлэл солилцон хамтран ажиллах механизмыг хэрэгжүүлэх гэрээ байгуулан ажиллах</p> <p>Уул уурхай эрхлэгчдийн хариуцлагын түвшинг тогтоож дүгнэх, зарлах, сайшаах, шүүмжлэх</p>
	5	ХУУ-н шалгуур үзүүлэлтээр уул уурхайн компаний үнэлгээнд дүн шинжилгээ хийн бодлогын зөвлөмж гаргаж, шийдвэр	ХУУ-г төлөвшүүлэхэд шаардагдах арга хэмжээ тодорхойлогдож, бодлогын зөвлөмжийг шийдвэр	Судалгааны багийн гаргасан уул уурхайн компаниудын хариуцлагын түвшинг тогтоосон үр дүнг УЗ-өөр хэлэлцүүлэх



**ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ
ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН
САНААЧЛАГА ТББ**



		гаргагчдад хүргүүлэх	гаргагчдад хүргүүлсэн байна.	<p>Судалгааны багийн гаргасан уул уурхайн компаниудын хариуцлагын түвшинг тогтоосон үр дүнд дүн шинжилгээ хийж, ХУУ-г төлөвшүүлэхийн тулд цаашид авах арга хэмжээг тодорхойлох</p> <p>ХУУ-г төлөвшүүлэхийн тулд цаашид авах арга хэмжээг тодорхойлон, зөвлөмж гаргаж оролцогч талуудад танилцуулах</p> <p>Шийдвэр гаргах түвшний хүрээнд лобби уулзалтууд зохион байгуулах</p>
Чиглэл 2				
Төр, иргэний нийгэм, үйлдвэрлэгчидээс бүрдсэн оролцогч талуудын хүрээг өргөжүүлэх, үйл ажиллагааны механизмыг боловсронгуй болгох, уулзалтуудыг тогтмолжуулах	1	Оролцогч талуудын уулзалтуудыг тогтмолжуулж, үйл ажиллагаа болон оролцогчдын хүрээг өргөжүүлэх	Олон талт оролцогч талуудын уулзалтыг жилд 4-өөс доошгүй удаа зохион байгуулж үйл ажиллагаа тогтмолжин, идэвхжинэ.	<p>Оролцогч талуудын нэгдсэн бүртгэлийг, үйл ажиллагааг зохицуулах тогтолцоог бий болгох</p> <p>Улаанбаатарт оролцогч талуудын уулзалт зохион байгуулах, хүрээг өргөжүүлэх</p> <p>Цаг үеийн тулгамдсан асуудлаар оролцогч талуудын хэлэлцүүлэг уулзалтууд хийх</p>



**ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ
ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН
САНААЧЛАГА ТББ**



	2	Орон нутагт ХУУ-н төлөөх оролцогч талуудын үйл ажиллагааг бий болгож дэмжигчдийн хүрээг өргөтгөх	ХУУ-н үйл ажиллагаа орон нутагт идэвхижиж, жилд 3-аас доошгүй аймагт оролцогч талуудын уулзалтыг зохион байгуулж, ХУУ-н хамтын ажиллагааны тогтолцоог орон нутагт төлөвшүүлнэ.	<p>Уул уурхай эрчимжсэн бүс нутгийг тодорхойлж, ХУУ-н төлөөх үйл ажиллагааг явуулах аймгуудыг сонгон, уулзалтуудыг зохион байгуулах</p> <p>Азийн сангийн Байгаль орчны хөтөлбөр хэрэгжиж буй аймгуудад ХУУ-н төлөөх үйл ажиллагааг уялдуулан хамтын ажиллагааг бүрдүүлэх</p> <p>Орон нутаг дахь байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудтай ХУУ-н төлөөх оролцогч талуудын үйл ажиллагааг уялдуулах</p>
Чиглэл 3				
ХУУ-н сургалт, судалгааны багийг байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулах ба олон нийттэй харилцах үйл ажиллагааг идэвхижүүлэх замаар ХУУ-н ойлголт, зарчим, түүний хэрэгжилтийг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх	1	ХУУ-н талаар үндэсний хэмжээнд сургалт явуулдаг байх	ХУУ-н талаархи ойлголтыг олон нийтэд системтэйгээр хүргэдэг сургалт мэдээллийн арга барил, сургалтанд ашиглах гарын авлагатай болно.	<p>Санаачлагын дэргэдэх сургалт явуулах мэргэжлийн багийг бүрдүүлэх</p> <p>ХУУ-н найман зарчмын үндсэн ойлголт, шалгуур үзүүлэлтийн тухай сургалтууд явуулах (гарын авлага боловсруулах)</p> <p>Гадаадын ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудтай хамтран тодорхой хэрэгцээнд тулгуурласан сургалтуудыг зохион байгуулах</p>



			ХУУ-н чиглэлээр их дээд сургуулиудад сургалт зохион байгуулах
2	ХУУ-н чиглэлээр судалгаа явуулдаг байх	ХУУ-н талаарх мэдээллийн базтай болно.	Санаачлагын дэргэдэх судалгааны багийг бүрдүүлэх
			Шалгуур үзүүлэлтүүдийг үнэлгээ хийх мэдээлэл цуглуулах, судалгаа хийх
3	ХУУ-н чиглэлээр сурталчилгаа явуулах	ХУУ-н талаарх мэдлэг, мэдээлэл мөн “Монгол улсад ХУУ-г төлөвшүүлэх” хөтөлбөрийн үйл явцыг ил тод, үнэн бодитоор олон нийтэд хүргэж Санаачлага нь монгол улсдаа төдийгүй олон улсад танигдаж хүлээн зөвшөөрөгдсөн “нөлөө бүхий” байгууллага болсон байна.	Уул уурхайн компаниудыг үнэлэн рейтинг тогтоох олон нийтийн үнэлэмжийн судалгааг вэб хуудсаар дамжуулан явуулдаг байх
			Уул уурхайн талаарх олон нийтийн хүлээлт, ойлголтын талаарх санал асуулга явуулах
			ХУУ-н асуудлаар мэргэшсэн сэтгүүлчдийн клуб байгуулж, тэднийг мэргэшүүлэх
			<p>Мэдлэг, мэдээлэл түгээх</p> <ul style="list-style-type: none"> • Баримтат нэвтрүүлэг бэлтгэх • Тогтмол гарах цахим болон хэвлэмэл сонинтой болох • Танилцуулга материал, гарын авлага бэлтгэн гаргах • Санаачлагын веб хуудсыг сайжруулах, 2 хэл дээр болгох, форум хэлбэрээр



**ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ
ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН
САНААЧЛАГА ТББ**



- оролцогч талуудын хэлэлцүүлэг хийдэг болгох
- Шалгуур үзүүлэлтийн талаарх олон нийт үнэлэмжийг вэб хуудсаар дамжуулан авдаг болох
- Нэгээс хоёр телевизийн байгаль орчин, уул уурхайтай холбоотой нэвтрүүлгүүдтэй хамтран ажиллах
- Хөтөлбөрийн хийх үйл ажиллагаанууд, шаардлага хэрэгцээ, үр өгөөж, олон улсын шилдэг туршлагуудын талаар оролцогч талуудыг жигд оролцуулсан цуврал ярилцлага өгөх, шууд нэвтрүүлэгт оролцох, ТВ шторк хийх
- Уул уурхайн салбарын тусгайлсан сонин, сэтгүүлүүд дээр ХУУ-н тусгай булан ажиллуулж, олон улсын туршлагууд, зарчмууд мөн хөтөлбөрийн явц болон үр дүнгийн талаар цуврал мэдээлэл тавих
- Салбарын үзэсгэлэн яармагт оролцон танилцуулга хийх, хэвлэмэл материалуудаа тараах, уул уурхайн салбарын компаниудтай харилцаа холбоо тогтоох
- ХУУ- н шалгуур үзүүлэлтийг хангах талаар сайн туршлагууд бий болгоод байгаа компаниудыг сурталчлах, тэдний



**ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ
ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН
САНААЧЛАГА ТББ**



				туршлагыг түгээн дэлгэрүүлэх талаар хамтран ажиллах	
Чиглэл 4					
<p>Зорилго: Байгууллагын бүтэц, үйл ажиллагааны чадавхийг сайжруулах/бэхжүүлэх Үр дүн: Санаачлага нь Монголын уул уурхайн салбарт чухал нөлөө үзүүлэхүйц чадамж бүхий байгууллагын хувьд үндэсний хэмжээнд хариуцлагатай уул уурхайг төлөвшүүлэх үйл явцыг манлайлан ажилладаг байгууллага болно.</p>	1	Байгууллагын бүтэц зохион байгуулалтыг өргөтгөх	Монгол улсад ХУУ-г төлөвшүүлэх чадвар бүхий бүтэцтэй болно.	Хавсралт. 1 харна уу	
	2	Удирдах зөвлөл, ажлын албыг чадавхижуулах	Дотоодын болон олон улсын хэмжээнд уул уурхайн бодит байдлыг судалж, ХУУ-н төлөөх зөв үнэлэлт, дүгнэлт өгөх чадварыг бий болгож, зорилтоо амжилттай хэрэгжүүлэх чадварлаг багтай болно.	Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компаниудад уулзалт аяллыг 2-оос доошгүй удаа зохион байгуулах	
				ХУУ-н үйл ажиллагаа явуулж буй орнуудад туршлага солилцох уулзалт, аяллыг 2-оос доошгүй удаа зохион байгуулах	
				Ажлын албыг шаардлагатай сургалтанд хамруулах	
					Удирдах зөвлөл болон ажлын албаны retreat-ыг жил бүрийн 6, 12 дугаар сард зохион байгуулах
	3	Байгууллагын санхүүгийн чадамжийг бэхжүүлэх	Санхүүгийн бэрхшээлгүйгээр үйл ажиллагаа цаг хугацаандаа хэрэгжих бололцоо бүрдэнэ.	Мэргэжлийн байгууллагаар Санаачлагын үйл ажиллагаанд болон санхүүд аудит хийлгэх	
Үйл ажиллагаанд зарцуулагдах санхүүгийн эх үүсвэрийг \түргэн шуурхай цаг тухайд нь\ тухайн цаг бүрт нь өгч байх					



**ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ
ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН
САНААЧЛАГА ТББ**



				Хяналтын зөвлөлд санхүүжүүлэгч талаас төлөөлөгч оруулж ажиллах
				Санхүүжилтийн журмыг танилцуулах



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН САНААЧЛАГА ТББ



Хавсралт.5

Хамтын ажиллагаа, түншлэлийн хүрээнд хийсэн уулзалт, хурлууд:

Санаачлагын богино хугацааны стратеги төлөвлөгөөний мэдээлэл, сурталчилгаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилгын хүрээнд дараах ажлууд хийгдлээ. Үүнд:

- ❖ Дэлхийн банкны монгол дахь суурин төлөөлөгчийн газар, Нийгмийн хариуцлагын сүлжээнээс 2009 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр зохион байгуулсан Видео уулзалтад Санаачлагаас гүйцэтгэх захирал Ч. Ундрам оролцлоо.
- ❖ Швейцарын хамтын ажиллагааны Монгол дахь суурин төлөөлөгчийн газрын Орон нутаг хариуцсан дэд захирал Matthias Meier-тай 2010 оны 1 сарын 20-ний 14:30 цагт Санаачлагын гүйцэтгэх захирал Ч. Ундрам уулзав.
- ❖ Уул уурхайн гэрээний хяналт ба удирдлагын зарим асуудал” сэдэвт олон нийтийн хэлэлцүүлэг 2010 оны 1 дүгээр сарын 21-ний өдөр Нээлттэй нийгэм форумын хурлын танхимд болж өнгөрлөө. Уг хэлэлцүүлэгт ТХХУУС-ын Удирдах Зөвлөлийн дарга А. Бакей мөн Удирдах зөвлөлийн гишүүн Б. Чинзориг нар оролцов.
- ❖ Канадын элчин сайдын яам “Хариуцлагатай уул уурхай-Байгууллагын нийгмийн хариуцлагын талаархи орчин үеийн хандлага “ сэдэвт семинарыг 2010 оны 1 сарын 25-ны өдөр Гадаад хэргийн яамны хурлын танхимд зохион байгуулсан ба уг семинарт Санаачлагыг төлөөлж гүйцэтгэх захирал Ч. Ундрам, Удирдах зөвлөлийн гишүүн Д. Сүхбаатар нар оролцов.
- ❖ Канадын Олон улсын хөгжлийн судалгааны төвийн дэмжлэгтэйгээр хэрэгжиж буй DREAM IT төслийн “Мэдээллийн технологи-хөгжилд” сэдэвт үндэсний семинар Чингис зочид буудалд 2010 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгуулагдлаа. Уг семинарт Санаачлагыг төлөөлж гүйцэтгэх захирал Ч. Ундрам оролцов.
- ❖ “Иргэний нийгмийн тогтвортой хөгжлийг хангах төрийн бодлого” чуулга уулзалт 2010 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр Төрийн ордны Б танхимд зохион байгуулагдлаа. Уг чуулга уулзалтанд гүйцэтгэх захирал Ч. Ундрам, Удирдах Зөвлөлийн гишүүн А. Бакей нар оролцов.
- ❖ Санаачлагын гүйцэтгэх захирал Ч. Ундрам Churchill компанийн захирал Barrie Evans-тай тэднийхээс ирүүлсэн хүсэлтийн дагуу 2010 оны 2 сарын 02-ны өдөр 11:00 цагт Санаачлагын ажлын албан дээр уулзалт хийв.
- ❖ МҮҮУА-ын дарга ноён Д. Ганболдтой Санаачлагын гүйцэтгэх захирал Ч. Ундрам 2010 оны 2 сарын 02-ны 10:30 цагт уулзалт хийж Санаачлагын санхүүжилтийн талаар санал солилцсон.
- ❖ Төлсөн авснаа нийтэл эвслийн 2009 оны үйл ажиллагааны тайлан, 2010 оны ажлын төлөвлөгөө хэлэлцэх бүх гишүүдийн хурал Нээлттэй нийгэм форумын хурлын танхимд 2010 оны 2 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулагдлаа. Уг хуралд Санаачлагын Удирдах зөвлөлийн гишүүн Л. Батнасан, Б. Баярмаа нар оролцсон.
- ❖ Оюу толгой төслийн урт хугацааны Соёлын өвийн хөтөлбөр хэрэгжүүлэхтэй холбоотой Зөвлөх үйлчилгээ үзүүлэх тендерийн талаар мэдээллийн өдөрлөг 2010 оны 02 сарын 05-



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН САНААЧЛАГА ТББ



- ны 14:30 цагт Чингис Хаан зочид буудалд болж өнгөрлөө. Уг нээлттэй өдөрлөгт Санаачлагын гүйцэтгэх захирал Ч. Ундрам оролцсон.
- ❖ 2010 оны 2 дугаар сарын 08-09-ний өдрүүдэд Төрийн ордонд зохион байгуулагдсан “Монгол улсын эдийн засгийн анхдугаар чуулга уулзалт”-нд Санаачлагын гүйцэтгэх захирал Ч. Ундрам оролцсон.
 - ❖ Канадын элчин сайдын яамнаас 2010 оны 2 дугаар сарын 11-ний оройн 18:00 цагт зохион байгуулсан PDAC 2010 NETWORKING хүлээн авалтанд Санаачлагыг төлөөлөн Удирдах зөвлөлийн гишүүн Д. Сүхбаатар болон гүйцэтгэх захирал Ч. Ундрам нар оролцов.
 - ❖ Санаачлагын гүйцэтгэх захирал Ч. Ундрам CHF International-ийн хөтөлбөрийн менежер Роберто Мэтьюс-тай тэднийхээс ирүүлсэн хүсэлтийн дагуу 2010 оны 02 сарын 11-ний өдөр 11:00 цагт Санаачлагын ажлын албан дээр уулзалт хийв.
 - ❖ Оюу толгой төслийн урт хугацааны Эрүүл мэндийн хөтөлбөрт РАСТ төслөөс хамтарч оролцох тухай санал ирүүлсэнтэй холбоотойгоор РАСТ төслийн эрүүл мэндийн зөвлөх Одноо-той Санаачлагын Удирдах зөвлөлийн дарга Д. Хэрлэн болон гүйцэтгэх захирал ч. Ундрам нар 2010 оны 02 сарын 11-ний өдөр 14:00 цагт Санаачлагын ажлын албан дээр уулзалт хийв.
 - ❖ Эрдэнэ Монгол компанийн Орон нутаг, нутгийн иргэд хариуцсан ажилтан Жон Лёонстой 2010 оны 02 сарын 23-ны 14:30 цагт Санаачлагын Удирдах зөвлөлийн дарга Д. Хэрлэн, УЗ гишүүн Б. Чинзориг, Л. Батнасан, Гүйцэтгэх захирал Ч. Ундрам нар энэ жил хэрхэн хамтарч ажиллах боломж байгаа талаар уулзалт хийв.
 - ❖ Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн ерөнхийлөгч ноён Д. Ганболдтой 2010 оны 3 дугаар сарын 1-ний өдөр Санаачлагын Удирдах зөвлөлийн дарга Д. Хэрлэн, гүйцэтгэх захирал Ч. Ундрам нар санхүүжилт, хамтын ажиллагааны талаар уулзалт хийв.
 - ❖ Айвенхоу Майз Монголия Инк-ийн гүйцэтгэх дэд захирал Лейтон Кропттой 2010 оны 3 дугаар сарын 9-ний өдөр Санаачлагын Удирдах зөвлөлийн дарга Д. Хэрлэн, гүйцэтгэх захирал Ч. Ундрам нар хамтын ажиллагааны талаар уулзалт хийв.
 - ❖ Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газраас зохион байгуулсан Туул голын усны нөөц, ус ашиглалт хамгаалалт зөвлөгөөн 2010 оны 3 дугаар сарын 11, 12-ны өдрүүдэд Монголын үйлдвэрчний эвлэлийн соёлын төв ордонд зохион байгуулагдлаа. Энэ зөвлөгөөнд Санаачлагыг төлөөлөн гүйцэтгэх захирал Ч. Ундрам оролцлоо.
 - ❖ Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн шинэ ерөнхийлөгч ноён Д. Дамбатай 2010 оны 3 дугаар сарын 22-ны өдөр Санаачлагын гүйцэтгэх захирал Ч. Ундрам нар санхүүжилт, хамтын ажиллагааны талаар уулзалт хийв.
 - ❖ Санаачлагын зүгээс өнгөрсөн намар Германы СИМ байгууллагад эксперт ажиллуулах санал тавьж, уулзалт хийж байсан билээ. Энэ үйл ажиллагааны үргэлжлэл болж Монгол Германы гүүр төрийн бус байгууллагын зөвлөх Хатантуултай Санаачлагын гүйцэтгэх захирал Ч. Ундрам 2010 оны 3 дугаар сарын 25-ны 10:00 цагт уулзалт хийлээ.
 - ❖ Монгол улсын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын Үндэсний зөвлөл, Ажлын хэсэг, Ажлын албанаас АМГ болон ГТГ-тай хамтран 2010 оны 3 дугаар сарын 23-ны өдөр Монросцветметийн хурлын танхимд уул уурхайн компаниудын удирдах болон санхүүгийн ажилтнуудад зориулсан "Гүйцэтгэх захирал Ч. Ундрам" нэртэй семинарыг зохион явуулсан.



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН САНААЧЛАГА ТББ



“Найаа-иёйн тайлангаа хугацаандаа гаргацгаая” сургалтанд Санаачлагын гүйцэтгэх захирал Ч. Ундрам оролцлоо.

- ❖ Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас 2010 оны 3 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулсан “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний хууль”-ийн хэлэлцүүлэгт Санаачлагыг төлөөлөн Удирдах зөвлөлийн гишүүн Г. Батсайхан, Л. Батнасан, Б. Чинзориг нар оролцож, хуулийн төсөлд тодорхой санал орууллаа.
- ❖ Ардчиллын боловсрол төвөөс 2010 оны 3 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулсан Нийгмийн хариуцлагын төлөв байдлын судалгааны танилцуулга уулзалтанд Санаачлагын гүйцэтгэх захирал Ч. Ундрам оролцлоо.
- ❖ Эрдэс баялаг, эрчим хүчний яам болон Ашигт малтмалын хэрэг эрхлэх газар, Монголын уул уурхайн үндэсний ассоциаци хамтран 2010 оны 3 дугаар сарын 26-ны өдөр Төрийн ордны А танхимд зохион байгуулсан “Уул уурхайн улсын нэгдсэн чуулга уулзалтанд Санаачлагыг төлөөлөн гүйцэтгэх захирал Ч. Ундрам, Удирдах зөвлөлийн гишүүн Г. Батсайхан нар оролцож уул уурхайн салбарын хууль, эрх зүйн асуудал, бүтэц зохион байгуулалт, бодлого хөтөлбөр зэрэг сэдвүүдээр хэлэлцлээ.
- ❖ Монголын уул уурхайн нэгдсэн мэдээллийн сангаас жил бүр гаргадаг Монголын уул уурхайн нэгдсэн лавлах 2010 номонд Санаачлага танилцуулга сурталчилгаагаа А4 хэмжээтэй нэг нүүрэнд англи монгол хэл дээр байршууллаа. Энэхүү танилцуулга сурталчилгааг оруулахад Мининфо компани нь Дисковер Монголиа 2009-ийн үеэр манайд тавьж байсан хамтран ажиллах саналынхаа хүрээнд үнийн дүнгийн 50% хөнгөлөлттэйгээр байршуулсан болно.
- ❖ Оюу толгой төслийн урт хугацааны Эрүүл мэндийн хөтөлбөрт хамтарч оролцсон төслийн багийнхантай 2010 оны 3 дугаар сарын 30-ны өдөр гүйцэтгэх захирал Ч. Ундрам Оюу толгойгоос ирүүлсэн тодруулах асуултуудад хариулт өгөх тухай уулзалт хийсэн болно.
- ❖ MCS группээс онцгой хэрэглэгчиддээ зориулан Делл брендийн бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ талаар уулзалт семинарыг 2010 оны 3 дугаар сарын 31-ны өдөр Чингис хаан зочид буудлын хурлын танхимд зохион байгуулсан бөгөөд уг уулзалтанд Санаачлагын гүйцэтгэх захирал Ч. Ундрам оролцлоо.
- ❖ Айвенхоу Майз Монголиа Инк-ийн Хасартай 2010 оны 4 дүгээр сарын 6-ны өдөр гүйцэтгэх захирал Ч. Ундрам уулзалт хийн, цаашдын хамтын ажиллагааны талаар тодорхой санал, асуудлуудыг солилцсон.
- ❖ Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас өнгөрсөн онд хэрэгжүүлж эхэлсэн Уул уурхайн нөхөн сэргээлт хийгдээгүй орхигдсон газруудын тооллогын төслийн үргэлжлэл ажил энэ жил мөн зохион байгуулагдахаар яамны төлөвлөгөөнд тусгагдсан байна. Энэ хүрээнд Санаачлага өнгөрсөн жил БОАЖЯ-нд хамтарч ажиллах санал хүргүүлж байсны үргэлжлэл болгон энэ жил уг төсөл дээр хэрхэн хамтарч ажиллах бололцоо байгаа талаар Удирдах зөвлөлийн гишүүн А. Бакей, БОАЖЯ-ны сайд ноён Л. Гансүхтэй 2010 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр уулзалт хийв.
- ❖ Уул уурхайн компанийн ханган нийлүүлэгчдийн Mine-Tech үзэсгэлэн 2010 оны 4 дүгээр сарын 8,9-ний өдрүүдэд Мишээл экспо төвд зохион байгуулагдлаа. Энэ үзэсгэлэнд Санаачлагын танилцуулгыг оролцогчдод 100%-ийг тарааж сурталчилгаа хийсэн болно.



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН САНААЧЛАГА ТББ



- ❖ Уул уурхайн салбарт тохиолдож болзошгүй ослын хор уршгийг арилгах чиглэлээр “Говийн чоно-2” сургалтыг Онцгой байдлын ерөнхий газар, Монгол Улсад суугаа АНУ-ын Элчин сайдын яамны цэргийн атташегийн алба, Хавай мужийн Гамшгийн удирдлага, хүмүүнлэгийн тусламжийн “Экселленс” төв хамтран 2010 оны 3 дугаар сарын 30-наас 4 дүгээр сарын 09-ний өдрүүдэд Онцгой байдлын ерөнхий газар дээр зохион байгууллаа. Сургалт, мэргэжлийн анги, томилгоот хүч хэрэгслийн тактикийн үзүүлэх сургууль гэсэн 3 үе шаттай зохиогдсон уг сургалтанд ТХХУУС-ын Удирдах зөвлөлийн гишүүн PhD. Л. Долгормаа “Хариуцлагатай уул уурхай гэж юу вэ? Уул уурхайн хариуцлагагүй байдал нь байгаль орчин, хүний аюулгүй байдалд хэрхэн сөргөөр нөлөөлж байгаа” тухай илтгэл тавилаа.
- ❖ Монгол дахь USAID/EPRC төслийн багийн ажилтан Ребекка Дарланг болон Баяраа нартай цаашдын хамтын ажиллагааны талаар Санаачлагын гүйцэтгэх захирал Ч. Ундрам болон Удирдах зөвлөлийн гишүүн Л. Батнасан нар 2010 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр уулзалт хийв.
- ❖ Монгол дахь USAID/EPRC төслийн байгууллагын 2010 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр Корпорэйт зочид буудалд болсон уулзалт хүлээн авалтанд Санаачлагын гүйцэтгэх захирал Ч. Ундрам оролцлоо.
- ❖ Монгол улсад суугаа Канадын элчин сайдын яамны Софи-тай хамтын ажиллагааны тухай Санаачлагын гүйцэтгэх захирал Ч. Ундрам болон Удирдах зөвлөлийн гишүүн Л. Батнасан нар 2010 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр уулзалт хийв.
- ❖ Хүний эрх-Хөгжил төвд ирсэн Америк мэргэжилтэнтэй тэднийхээс ирүүлсэн саналын дагуу Хүний эрх- Хөгжил төвийн үйл ажиллагааны талаар Санаачлагын гүйцэтгэх захирал Ч. Ундрам 2010 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр уулзалт хийв.
- ❖ МУУҮА-ийн гүйцэтгэх захирал ноён Алгаатай Санаачлагын гүйцэтгэх захирал Ч. Ундрам, Удирдах зөвлөлийн гишүүн А. Бакей нар 2010 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр Санаачлагад МУУҮА-иас өгөхөөр амласан санхүүжилтийн талаар уулзалт хийв.
- ❖ Монголын байгаль орчныг хамгаалах иргэний хөдөлгөөнүүдийн эвслээс 2010 оны 5 сарын 24-ний өдөр Орон нутгийн байгаль хамгаалах иргэний хөдөлгөөнүүдийнхэн болон сум орон нутгийн удирдлагад хийсэн сургалтанд оффис менежер М. Ганчимэг Санаачлагыг танилцуулан, ХУУ-н тухай хичээл заасан.
- ❖ Камбож улсад энэ оны 5 дугаар сарын 26-28-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Олон улсын уул уурхайн чуулган”-д Санаачлагад ирсэн урилгын дагуу Удирдах зөвлөлийн гишүүн З. Батбаяр оролцоод ирсэн.
- ❖ Уул уурхай нь эрүүл мэндэд нөлөөлөх үнэлгээний аргачлал боловсруулах төслийн Зөвлөх багийн анхны уулзалт ЗГХА-ЭМГ-т 2010 оны 6 сарын 8-ны өдөр болов. Уулзалтанд холбогдох яамд, төрийн болон төрийн бус, олон улсын байгууллага, уул уурхайн компанийн төлөөлөл бүхий нийт 23 шийдвэр гаргах түвшний хүмүүс оролцсон бөгөөд энэ уулзалтанд Санаачлагыг төлөөлөн Ажлын албаны Оффис менежер М. Ганчимэг оролцож мэдээлэл авсан болно.
- ❖ Мянганы Сорилтын Сангийн ТМБС-ын Төсөл, “Бодлого, Үйл ажиллагааны хүрээний шинэчлэл”-ийн дэд төслийн багаас Уул уурхайн салбарын зөвлөлийн семинарыг өнгөрсөн 6 сарын 15-ны өдөр Улаанбаатар зочид буудлын Хөх Асар танхимд зохион



ТОГВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН САНААЧЛАГА ТББ



- байгуулсан бөгөөд, тус уулзалтанд Санаачлагыг төлөөлөн Гүйцэтгэх захирал Ч. Ундрам, Удирдах Зөвлөлийн гишүүн Л. Долгормаа нар оролцсон болно.
- ❖ Дэлхийн Эдийн засгийн форумын үргэлжлэл уулзалт FAIR MINERAL DEVELOPMENT INITIATIVE WORKSHOP өнгөрсөн 6 сарын 17,18-ны өдрүүдэд Монгол улс Их тэнгэр цогцолборт зохион байгуулагдсан билээ. Энэ уулзалтанд Санаачлагыг төлөөлөн Гүйцэтгэх захирал Ч. Ундрам оролцсон болно.
 - ❖ БОАЖЯ-аас 2010 оны 6 сарын 17-ны өдөр зохион байгуулсан Монгол улсын байгаль орчны мастер төлөвлөгөө 2010-2025 бодлогын баримт бичгийн хэлэлцүүлэгт Санаачлагыг төлөөлөн Ажлын албаны Оффис менежер М. Ганчимэг оролцож мэдээлэл авсан болно.
 - ❖ Ази номхон далайн орнуудын Нийгмийн хариуцлагын төлөөх сүлжээ-ний уулзалт 2010 оны 6 сарын 22-24-ний өдрүүдэд Улаанбаатар хотоос 25 км зайд байрлах Хаан жимс амралтын газар зохион байгуулагдсан тус сүлжээний стратеги төлөвлөгөө боловсруулах, 2010-2011 оны ажлын төлөвлөгөө гаргах уулзалтанд Санаачлагын гүйцэтгэх захирал Ч. Ундрам оролцсон болно.
 - ❖ Америкийн нэгдсэн улсын Азийн сангаас 2010 оны 6 сарын 25-ны өдөр зохион байгуулсан Санхүүжилт хүлээн авагчийн сургалтанд Санаачлагын Ажлын албаны Оффис менежер М. Ганчимэг сууж, цаашид Азийн сангаас санхүүжилт авахад анхаарах зүйлс болон, тайлан мэдээг хэрхэн гаргах талаар суралцсан болно.
 - ❖ 2010 оны 9 сарын 8-9-ний өдрүүдэд зохион байгуулагдсан Уул уурхайн олон улсын хөрөнгө оруулагчдын чуулга уулзалтад Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн дэмжлэгтэйгээр УЗ-ийн гишүүн Л. Долгормаа “Монгол улсад хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх нь” сэдвээр илтгэл тавьж оролцсон. Мөн Санаачлага уг чуулга уулзалтын үзэсгэлэнгийн талбайд Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагатай хамтран байрлаж, байгуулагаа танилцуулсан.
 - ❖ Санаачлагын 2010 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 2.6. “Уул уурхайн компаниудын дунд форум, семинар, чуулга уулзалт зохион байгуулж туршлага солилцуулах, үүнд ТББ, төрийн байгууллагуудын төлөөллийг оролцуулах” дагуу, мөн “Уул уурхайн компанийн орон нутаг, нутгийн иргэд хариуцсан ажилтнуудад зориулсан” сургалтын үеэр уул уурхайн компаниудаас ирсэн саналыг үндэслэн Санаачлага “Social responsibility practitioners network” буюу уул уурхайн компаниуд дунд орон нутагтай харилцах туршлага солилцох сүлжээг бий болгох ажлын төслийг боловсруулан, төслийн саналаа Дэлхийн банкинд хүргэсэн. Энэхүү ажлын Дэлхийн банк дэмжихээ мэдэгдсэн. Одоо Санаачлага энэ ажлын хүрээнд уул уурхайн компаниудын орон нутаг нутгийн иргэдтэй хамтран ажилладаг ажилчдын дунд сүлжээ үүсгэх, туршлага солилцох форумыг 2010 оны 12 сарын 6,7-ний өдрүүдэд зохион байгуулсан.
 - ❖ 2010 оны 7 сарын 28-ны өдөр Их Британы уул уурхайн чиглэлээр бичдэг чөлөөт сэтгүүлч Кит Жиллетээс ирсэн хүсэлтийн дагуу Гүйцэтгэх захирал Ч. Ундрам Монгол улсын уул уурхайн өнөөгийн байдлын талаар болон Санаачлагыг танилцуулах уулзалт хийсэн.



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН САНААЧЛАГА ТББ



- ❖ 2010 оны 8 сарын 17-ны өдөр Ардчилалын боловсрол төв дээр болсон Нийгмийн хариуцлагын төлөөх сүлжээний тайланг хэлэлцэх видео хурлын бэлтгэл уулзалтад Гүйцэтгэх захирал Ч. Ундрам оролцсон.
- ❖ 2010 оны 8 сарын 19-ны өдөр ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн сайд Дирк Нийбэл тэргүүтэй төлөөлөгчдийн айлчлалын хүрээнд Монгол Германы иргэний нийгмийн байгууллын төлөөлөгчдийн уулзалтанд Гүйцэтгэх захирал Ч. Ундрам, Хөгжил харилцаа хариуцсан мэргэжилтэн О. Батболд нар оролцож, Санаачлагыг танилцуулах илтгэл тавьж Германы байгууллагуудтай хамтран ажиллах эхлэл тавигдсан.
- ❖ 2010 оны 8 сард Дэлхийн эдийн засгийн форумаас гарсан Эрдэс баялгийн хөгжил ТББ-ын Монгол улс дахь үнэлгээний ажилд Гүйцэтгэх захирал Ч. Ундрам ярилцлага өгсөн.
- ❖ 2010 оны 8 сарын 24-ний өдөр ХБНГУ-ын Геошинжлэх Ухаан, Байгалийн Нөөцийн Холбооны Хүрээлэнгийн “Уул уурхайн салбар дахь байгаль орчны хамгаалал”-төслийн удирдагч ДокторТекла Абел-тай Гүйцэтгэх захирал Ч. Ундрам, Хөгжил харилцаа хариуцсан мэргэжилтэн О. Батболд нар уулзаж хамтын ажиллагааны эхлэл тавигдсан. Энэ уулзалтын үр дүнд “Уул уурхайн салбар дахь байгаль орчны хамгаалал” төсөл нь Санаачлага болон Австралийн Квийнсландын их сургуулийн Уул уурхайн нийгмийн хариуцлагын төвтэй хамтран зохион байгуулсан сургалтад 2 сая орчим төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.
- ❖ 2010 оны 8 сарын 30-ны өдөр Монгол улс дахь USAID-ийн үнэлгээний ажилд Гүйцэтгэх захирал Ч. Ундрам ярилцлага өгсөн.
- ❖ 2010 оны 9 сарын 6-ны өдөр Их Британийн ВВС телевизийн сэтгүүлч Пам-тай Гүйцэтгэх захирал Ч. Ундрам уулзан Монгол улсын уул уурхайн өнөөгийн байдлын талаар ярилцаж, Санаачлагыг танилцуулсан.
- ❖ 2010 оны 9 сарын 7-ны өдөр Германы элчин сайдын яамнаас зохион байгуулсан Монгол улсад ирж буй уул уурхайн хөрөнгө оруулагч Германы байгууллагуудтай хийсэн хүлээн авалтад Хөгжил харилцаа хариуцсан мэргэжилтэн О. Батболд оролцсон.
- ❖ 2010 оны 9 сарын 8-ны өдөр Гүйцэтгэх захирал Ч. Ундрам Азийн сангийн Байгаль орчны хөтөлбөрийн дарга Энжи Вү-тэй хамтын ажиллагааны талаар уулзалт хийсэн.
- ❖ 2010 оны 09 сарын 14-ний өдөр Оюу Толгой ХХК-д ирж буй судалгааны багийнхан Өмнөговь аймгийн суурь судалгаа хийх зөвлөх хороонд оролцож байсан манай гишүүдтэй уулзах хүсэлт тавьсаны дагуу Гүйцэтгэх захирал Ундрам, УЗ-ийн гишүүн Б. Чинзориг нар уулзаж, Өмнөговь аймгийн зөвлөх хороо хэрхэн ямар зарчимаар ажилласан тухай илтгэл тавьсан.
- ❖ 2010 оны 9 сарын 13-ны өдөр дэлхийн банкин дээр зохион байгуулагдсан Нийгмийн хариуцлагын төлөөх сүлжээний төрийн байгууллагаас үзүүлж буй ажил үйлчилгээнд үнэлгээ өгөх төслийн үйл ажиллагааны талаар хэлэлцэх уулзалтанд Гүйцэтгэх захирал Ч. Ундрам оролцсон.
- ❖ 2010 оны 9 сарын 14-ний өдөр Нээлттэй нийгэм форум дээр зохион байгуулагдсан Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлага (ОУИТБС)-ын Олон улсын нарийн бичгийн дарга нарын газрын Төв Азийн бүс нутаг болон Баталгаажуулалтын асуудлыг хариуцсан захирал ноён Сэм Бартлэт Төлсөн Авснаа Нийтэл (ТАН) эвслийн гишүүн байгууллагуудын төлөөлөлтэй ОУИТБС-ын Монгол Улсын



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН САНААЧЛАГА ТББ



- баталгаажуулалттай холбоотой асуудлаар санал солилцох уулзалтанд ажлын албаны Оффис менежер М. Ганчимэг оролцсон.
- ❖ 2010 оны 9 сарын 14-ний өдөр ХБНГУ-ын Олон улсын шилжилт хөдөлгөөн, хөгжлийн төвийн Эх орондоо эргэн ирэх хөтөлбөрийн дарга Доктор Увэ Кивелицтэй Гүйцэтгэх захирал Ч. Ундрэм, Хөгжил харилцаа хариуцсан мэргэжилтэн О. Батболд нар уулзаж, Санаачлагын үйл ажиллагааны талаар танилцуулсан. */Энэ хөтөлбөрийн хүрээнд Хөгжил харилцаа хариуцсан мэргэжилтэн О. Батболд нь Санаачлагатай 2 жилийн гэрээтэй ажиллаж бйагаа, мөн ирэх оны эхээр Герман мэргэжилтэн Санаачлагад ирж ажиллах гэж байгаа билээ. /*
 - ❖ 2010 оны 9 сарын 14-ний өдөр Азийн сангийн Монгол дахь суурин төлөөлөгч Мелони Линдбергийн урилгаар Гүйцэтгэх захирал Ч. Ундрэм Лаосын засгийн газрын зочид төлөөлөгчидтэй Монгол дахь усны чанарын хяналтын асуудлаар хийсэн хүлээн авалтад оролцсон.
 - ❖ 2010 оны 9 сарын 14-ний өдөр Гүйцэтгэх захирал Ч. Ундрэм, Хөгжил харилцаа хариуцсан мэргэжилтэн О. Батболд нар Күй Жи Экс ХХК-ын Орон нуаг, олон нийттэй харилцах хэлтэсийн дарга А. Сүхбаатар */Санаачлага, Квийнсландын их сургуулийн хамтран 2010.08.30-09.01-ний хооронд зохион байгуулсан сургалтад хамрагдсан/*, гэрээний хуульч Ламжав, хуулийн зөвлөх Х. Наранбулаг нартай тэднийхээс ирүүлсэн хүсэлтийн дагуу уулзаж Орон нутагт ямар байдлаар үйл ажиллагаа явуулах, орон нутагтай харилцах албыг ямар хэлбэрээр байгуулах талаар зөвлөгөө өгч, санал солилцсон. Энэ уулзалтын үр дүнд Күй Жи Экс ХХК-ын сургалт хариуцсан менежер Л. Мөнхнарантай уулзаж орон нутаг хариуцсан ажилтнуудад зориулсан сургалтыг USAID-ын Эдийн засгийн бодлогын өрсөлдөх чадвар төсөлтэй хамтран зохион байгуулах ажлын эхлэлийг тавьж өгсөн.
 - ❖ 2010 оны 9 сарын 15-17-ны өдрүүдэд Булган аймагт Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Уул уурхайн салбар дахь байгаль орчны хамгаалал төсөл, Пибоди Винсвэй Ресорсиз ХХК, Одод Гоулд ХХК-уудын хамтран зохион байгуулсан “Уурхайн хаалтын менежмент” V үзүүлэх сургалтад Хөгжил харилцаа хариуцсан мэргэжилтэн О. Батболд оролцсон.
 - ❖ 2010 оны 9 сарын 21-ний өдөр Санаачлагын Гүйцэтгэх захирал Ч. Ундрэм, Хөгжил харилцаа хариуцсан мэргэжилтэн О. Батболд нар Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн Монгол дахь хөтөлбөрийн дарга Сабине Мюлер, “Хөрөнгө оруулалтын бодлогын стратегийн зөвлөгөө төсөл”-ийн удирдагч Стефан Ханзелман нартай хамтын ажиллагааны талаар уулзалт хийсэн.
 - Энэ уулзалтын үр дүнд “Хөрөнгө оруулалтын бодлогын стратегийн зөвлөгөө төсөл”-д зөвлөхөөр ирсэн Доктор Ханс Юрген Райтер ажлын албатай ярилцсаны дагуу “Байгууллагын хөгжил болон олон талуудтай хамтран ажиллах арга барилын талаар сургалт”-ыг Санаачлагын ажлын алба болон Удирдах зөвлөлийн гишүүдэд зориулан 2010 оны 10 сарын 1-ний өдөр хийлээ. Уг сургалтад Санаачлагын ажлын алба, УЗ-ийн гишүүн Д. Сүхбаатар, С. Хасар нар оролцсон.
 - Мөн дээрх уулзалтын дүнд Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн */ГТХАН-ийн/* Монгол дахь хөтөлбөр нь Санаачлагыг цаашид



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН САНААЧЛАГА ТББ



хамтран ажиллах 5 сэдэв болон чиглэлээ ирүүлнэ үү гэсэн бөгөөд одоогоор Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэгтэй бид дараах 4 чиглэлээр хамтран ажиллах боломжтой юм байна. Үүнд:

- Олон талт хүмүүсийг оролцуулсан хэлэлцүүлэг, форум хийх
 - Дэлхийн банкны дэмжлэгээр зохион байгуулахаар болоод байгаа “Уул уурхайн компаниудын орон нутаг нутгийн иргэдтэй хамтран ажилладаг ажилчдын дунд сүлжээ үүсгэх, туршлага солилцох форум”-д ГТХАН нь өөрсдийн цуглуулсан мэдлэг, мэдээлэл, туршлагын хүрээнд Санаачлагатай хамтран ажиллах
 - ХБНГУ-ын Олон улсын шилжилт хөдөлгөөн, хөгжлийн төвийн Эх орондоо эргэн ирэх хөтөлбөрийн шугамаар герман мэргэжилтэн Санаачлагад ирж ажиллах
 - Германы ахлах мэргэжилтнүүдийг Санаачлагад урьж авчрах зэрэг орно.
 - Та бүхэн ГТХАН-тай хамтран ажиллах уул уурхайтай холбоотой 5 сэдэв нь ямар сэдвүүд байвал дээр вэ гэдэг дээр өөрсдийн саналаа мөн ажлын албанд ирүүлнэ үү.
 - 2010 оны 9 сарын 23-ны өдөр USAID-ын Эдийн засгийн бодлогын өрсөлдөх чадвар төслийн Уул уурхай хариуцсан ахлах мэргэжилтэн Рена Гуандуэз болон Олон нийттэй харилцах асуудал хариуцсан менежер Меган О Нэйл нартай Гүйцэтгэх захирал Ч. Ундрэм, Хөгжил харилцаа хариуцсан мэргэжилтэн О. Батболд нар USAID-ын Эдийн засгийн бодлогын өрсөлдөх чадвар төсөл, Монголын хэвлэлийн хүрээлэн, Дэлхийн банк мөн бусад олон улсын ивээн тэтгэгчдийн дэмжлэгээр үүсгэн байгуулагдсан “Уул уурхай нийгмийн хариуцлагын чиглэлээр ажилладаг эдийн засгийн сэтгүүлчдийн клуб”-тэй хамтран ажиллах талаар уулзалт хийсэн. Энэ уулзалтын дүнд 2010 оны 11-р сард “Уул уурхай нийгмийн хариуцлагын чиглэлээр ажилладаг эдийн засгийн сэтгүүлчдийн клуб”-ийн сэтгүүлчдэд зориулсан сургалтыг USAID-ын Эдийн засгийн бодлогын өрсөлдөх чадвар төсөлтэй хамтран зохион байгуулахаар болоод байна.
- ❖ 2010 оны 10 сарын 5-ны өдөр Дэлхийн банкин дээр 2010 оны 12 сарын 7,8-ны өдрүүдэд зохион байгуулах “Уул уурхайн компаниуд дунд орон нутагтай харилцах туршлага солилцох сүлжээг бий болгох” чуулга уулзалтын талаар форумыг зохион байгуулагчидтай Гүйцэтгэх захирал Ч. Ундрэм уулзсан.
 - ❖ 2010 оны 10 сарын 6-ны өдөр Пакт Монгол төслийн шинэ менежер Дэвид Якобштэйн-тэй Гүйцэтгэх захирал Ч. Ундрэм байгууллагаа танилцуулан, Оюу толгой компанийн урт хугацааны Эрүүл мэндийн хөтөлбөрийн эхлэл ажил хэрхэн явагдаж буй, Санаачлага энэ ажилд цаашид хэрхэн оролцох талаар уулзалт хийсэн.
 - ❖ 2010 ны 10 сарын 8-ний өдөр ГТХАН-ийн “Хөрөнгө оруулалтын бодлогын стратегийн зөвлөгөө” буюу GTZ-IPAS төслийн “Эрсдэлийн менежмент” сэдэвт сургалтад Байгууллагын хөгжил, харилцаа хариуцсан мэргэжилтэн О. Батболд оролцсон.
 - ❖ 2010 оны 10 сарын 11-ний өдөр АНУ-ын хөгжлийн хөтөлбөрийн Эдийн засгийн бодлогын өрсөлдөх чадвар төслийн Уул уурхай хариуцсан ахлах мэргэжилтэн Рена Гундуз, АНУ-ын Азийн сангийн Байгаль орчныг хамгаалахад талуудын оролцоог нэмэгдүүлэх нь хөтөлбөрийн дарга Энжи Вү, болон Гүйцэтгэх захирал Ч. Ундрэм нар



ТОГВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН САНААЧЛАГА ТББ



Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд болон иргэний нийгмийн байгууллагуудын дунд уул уурхайн үйл ажиллагааны процессын тухай сургалт хамтран зохион байгуулах тухай ярилцсан.

- ❖ 2010 оны 10 сарын 13-ны өдөр Дэлхийн банк дээр болсон 10 сарын 16-27-ны өдрүүдэд Пилиффин улсын Манила хотод зохион байгуулагдах Нийгмийн хариуцлагын төлөөх сүлжээний уулзалтын талаарх хуралд Гүйцэтгэх захирал Ч. Ундрам оролцсон.
- ❖ 2010 оны 10 сарын 19-ний өдөр ГТХАН-ийн “Хөрөнгө оруулалтын бодлогын стратегийн зөвлөгөө” буюу GTZ-IPAS төсөлд ирсэн ахлах мэргэжилтэн Клаус Гартнертай Байгууллагын хөгжил харилцаа хариуцсан мэргэжилтэн О. Батболд болон Оффис менежер М. Ганчимэг нар уулзаж, байгууллагаа танилцуулсан болно.
- ❖ 2010 оны 10 сарын 21-11 сарын 7-ний өдрүүдэд Байгууллагын хөгжил, харилцаа хариуцсан мэргэжилтэн О. Батболд Германы Берлин, Бонн-д FES, СИМ-ийн шугамаар зохион байгуулагдах Эх орондоо эргэн ирэх сургалтад зохион байгуулагчаар, ГТХАН-ийн Фабиантай Санаачлагад ирэх оны эхээр ирэх Герман мэргэжилтнийг хурдан ирүүлэх талаар уулзан, албан бичиг хүргэсэн. Мөн 2010 оны 10 сарын 29-өөс 31-ны хооронд Штуттгарт хотноо зохион байгуулагдсан Хамтдаа хүчтэй сэдэвт Германд төгссөн болон одоо сурч буй монголчуудын эрдэм шинжилгээний хуралд “ХУУ Монголд” сэдэвээр илтгэл тавин оролцсон.
- ❖ 2010 оны 10 сарын 29-ний өдөр АНУ-ын Азийн сангаас санхүүжигч байгууллагуудда зориулсан санхүүгийн сургалтад Гүйцэтгэх захирал Ч. Ундрам оролцсон.
- ❖ 2010 оны 11 сарын 10-ны өдөр Иргэний Альянс төвд ирүүлсэн урилгын дагуу Гүйцэтгэх захирал Ч. Ундрам, О. Батболд нар Ил тод, хариуцлагатай, харилцан ашигтай уул уурхайг дэмжин гурван талт үндэсний зөвшилцөл байгуулахад ТББ-уудын хамтран ажиллах ёнаамж бичгийг дэмжих зөвлөгөөнд оролцож Санаачлагын байр суурийг илэрхийлсэн. Энэ асуудлыг 12 сарын 4, 5-нд болох Удирдах зөвлөлийн хурлаар шийдвэрлүүлэхээр болсон.
- ❖ 2010 оны 11 сарын 10-ны өдөр Макромайн компаний хамтран ажиллах санал тавьсаны дагуу тус компаний захирал Төгөлдөр, ажилтанууд Б. Батсайхан, Б. Ундрах нартай Байгууллагын хөгжил харилцаа хариуцсан мэргэжилтэн О. Батболд уулзалт хийсэн. Уулзалтаар 2011 онд хамтран “Уул уурхай мэдээллийн технологи” экспо зохион байгуулах талаар ярилцсан. Ирэх жилийнхийг илүү нарийвчилсан байдлаар хийх саналтай байсан ба Санаачлагын зүгээс эхний байдлаар төсөл боловсруулахаар болсон.
- ❖ 2010 оын 11 сарын 18-ны өдөр Санаачлагын Монгол улсад хариуцлагатай уул уурхайг төлөвшүүлэх төслийн хүрээнд Хариуцлагатай уул уурхайн шалгуур үзүүлэлтийг Оюу толгой компанид турших туршилтын ажлыг эхлүүлэх талаар Гүйцэтгэх захирал Ч. Ундрам Оюу толгой компанийн Олон талын оролцоо хариусан зөвлөх С. Хасартай уулзсан болно. Одоогоор туршилтын төслийн бэлтгэл ажлууд хийгдэж байна.
- ❖ 2010 оын 11 сарын 18-ны өдөр Санаачлага болон Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн хөтөлбөр, “Хөрөнгө оруулалтын бодлогын стратегийн зөвлөгөө төсөл”- ийн хамтын ажиллагааны хүрээнд Санаачлагын ажлын алба болон Удирдах зөвлөлийн гишүүдэд зориулан явуулж буй 2 дахь сургалтыг Доктор Юрген Шепер “Байгууллагын хөгжилийн төлөвлөлт, санхүүгийн төлөвлөлт, хөгжилийн хамтын ажиллагааны стратегийн төлөвлөлт” сэдвээр явуулсан болно. Уг



ТОГВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН САНААЧЛАГА ТББ



сургалтад Санаачлагын Удирдах зөвлөлийн гишүүн Г. Батсайхан, Д. Сүхбаатар болон ажлын алба оролцсон.

- ❖ 2010 оын 11 сарын 19-ний өдөр АНУ-ын Азийн сангийн Байгаль орчныг хамгаалахад талуудын оролцоог нэмэгдүүлэх нь хөтөлбөрийн дарга Энжи Вү, болон Гүйцэтгэх захирал Ч. Ундрэм нар уулзаж, Санаачлага Азийн сантай хамтран хэрэгжүүлэх Монгол улсад хариуцлагатай уул уурхайг төлөвшүүлэх төслийн эхлэл ажлын явцын талаар уулзаж ярилцсан.
- ❖ 2010 оын 11 сарын 22-ны өдөр Германы техник, хамтын ажиллагааны нийгэмлэгийн хөтөлбөрийн дарга Сабине Мюлер, Др. Ханзелман нартай Гүйцэтгэх захирал Ч. Ундрэм, О. Батболд нар цаашдын хамтын ажиллагааны талаар уулзсан. Уг уулзалтын дүнд Германы техник, хамтын ажиллагааны нийгэмлэг нь Санаачлагын стратеги төлөвлөгөөнд тусгагдсан Хариуцлагатай уул уурхайн мэдээллийн төвийг байгуулахад санхүүжүүлэн, хамтарч ажиллахаа мэдэгдээд байна.
- ❖ 2010 оны 11 сарын 23-27-ны өдрүүдэд Гүйцэтгэх захирал Ч. Ундрэм, Байгууллагын хөгжил харилцаа хариуцсан мэргэжилтэн О. Батболд, Байгууллагын арга хэмжээ хариуцсан ажилтан П. Соёлмаа нар Дэлхийн банктай хамтран 2010 оны 12 сарын 7,8-ны өдрүүдэд зохион байгуулах “Уул уурхайн компаниуд дунд орон нутагтай харилцах туршлага солилцох сүлжээг бий болгох” чуулга уулзалтын талаар уул уурхайн компаниудтай уулзалт хийсэн.
- ❖ 2010 оны 11 сарын 24-25-ны өдрүүдэд Байгаль орчны ТББ-уудын улсын 2-р зөвлөлгөөнд Гүйцэтгэх захирал Ч. Ундрэм оролцсон.
- ❖ 2010 оны 11 сарын 25-ны өдөр Оюу толгой компанийн урт хугацааны Эрүүл мэндийн хөтөлбөрийн багийнханы уулзалтад Байгууллагын хөгжил харилцаа хариуцсан мэргэжилтэн О. Батболд оролцсон.
- ❖ 2010 оны 11 сарын 30-ны өдөр АНУ-ын Азийн сангийн Байгаль орчныг хамгаалахад талуудын оролцоог нэмэгдүүлэх нь хөтөлбөрийн албан ёсны нээлтийн үйл ажиллагаанд Удирдах зөвлөлийн дарга Д. Хэрлэн, гишүүн Л. Долгормаа, З. Энхболд, Б. Баярмаа, гүйцэтгэх захирал Ч. Ундрэм, О. Батболд нар оролцсон.



ТОГВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН САНААЧЛАГА ТББ



Хавсралт. 6

Хэвлэл, нийтлэл, ярилцлага

1. Санаачлагын үйл ажиллагааг олон нийтэд танилцуулах зорилгоор Геологи уул уурхайн мэдээ, Улаанбаатар таймс сонингуудад тус сонингийн газруудаас ирүүлсэн хүсэлтийн дагуу гүйцэтгэх захирал Ч. Ундрам ярилцлага өгсөн.
2. Гадаад хэргийн яам, Ирмүүн агентлаг хамтран эрхлэн гаргадаг Монголика сэтгүүл нь дэлхийн 20 гаруй оронд англи хэл дээр хэвлэгдэн, Монгол улсын элчин сайдын яамдаар дамжин тараагддаг байна. Энэ сэтгүүл нь 2010 оны 4 дүгээр сарын дугаараас эхлэн уул уурхайн тусгай булантай болж байгаа бөгөөд энэ буланд Санаачлагын Удирдах зөвлөлийн гишүүн Г. Батсайхан, Л. Долгормаа, А. Бакей, Дамба, Б. Баярмаа гүйцэтгэх захирал Ч. Ундрам нар ярилцлага өгсөн болно.
3. Санаачлагаас боловсруулж байгаа Хариуцлагатай уул уурхайн шалгуур үзүүлэлт боловсруулах, турших үйл ажиллагаа, явцыг олон нийтэд танилцуулах зорилгоор Геологи уул уурхайн мэдээ сонинд тус сонингийн газраас ирүүлсэн хүсэлтийн дагуу Санаачлагын Удирдах зөвлөлийн гишүүн Г. Батсайхан, Л. Долгормаа нар ярилцлага өгсөн.
4. Санаачлагын олон нийттэй харилцах ажлын хүрээнд Ийгл ТВ-н “Уурхайн гүнд”, уул уурхайн мэдээллийн сан www.Mining.mn буюу Мининфо ХХК, Геологи уул уурхайн мэдээ зэрэг хэвлэл мэдээллийнхэнтэй хамтран ажиллах уулзалт ажлууд явагдаж байна. “Хөгжлийн төлөөх сэтгүүл зүй” ТББ-тэй хамтран хамтран ажиллах талаар Хөгжил, харилцаа хариуцсан мэргэжилтэн О. Батболд уулзсаны дүнд Уул уурхайн сэтгүүл Mining journal-ийг 50% хөнгөлөлттэй үнээр бүтэн жил захиалахаар болоод байна.
5. 2010 оны 11 сарын 11-ний өдөр Боловсрол суваг телевизээс ирсэн хүсэлтийн дагуу Гүйцэтгэх захирал Ч. Ундрам байгууллагаа танилцуулах, Хариуцлагатай уул уурхайн найман зарчим, түүний шалгуур үзүүлэлтийн талаар телевизийн ярилцлага өгсөн. Одоогоор Санаачлага нь уг Боловсрол суваг телевизтэй хамтран ажиллахаар Хамтын ажиллагааны санамж бичиг солилцох шатандаа явж байна.
6. 2010 оны 11 сарын 25-ны өдөр Өглөөний мэдээ сонингийн хүсэлтийн дагуу Гүйцэтгэх захирал Ч. Ундрам Хариуцлагатай уул уурхайн талаар ярилцлага өгсөн. Ярилцлагыг 12 сарын 6-аас 10-ны хооронд нийтлэгдэхээр яриж байна.
7. 2010 оны 11 сарын 25-ны өдөр Хэвлэлийн хүрээлэнгийн Уул уурхай, эдийн засгийн чиглэлээр бичдэг сэтгүүлчидтэй тэднийхээс ирсэн хүсэлтийн дагуу Санаачлагын Удирдах зөвлөлийн гишүүн Г. Батсайхан, Байгууллагын хөгжил харилцаа хариуцсан мэргэжилтэн О. Батболд нар Хариуцлагатай уул уурхайн талаар уулзалт хийсэн.
8. 2010 оны 12 сарын 7-8ны өдрүүдэд Санаачлага болон Дэлхийн банк, АНУ-ын хөгжлийн хөтөлбөрийн “Эдийн засгийн бодлогын өрсөлдөх чадвар төсөл”, Канадын Олон улсын худалдаа, гадаад хэргийн газар, Квийнсландын их сургуулийн уул уурхайн нийгмийн хариуцлагын төвийн дэмжлэгтэйгээр зохион байгуулсан “Уул уурхай ба орон нутаг, нутгийн иргэдийн харилцаа” сэдэвт чуулга уулзалтын талаар Геологи уул уурхайн мэдээ, Монголын радио, зэрэг хэвлэл нийтлэлд ярилцлага өгсөн.